



МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

УИХ-ын Аюулгүй байдал, гадаад бодлогын Байнгын хорооны саналын дагуу хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан



Улсын төсвөөс санхүүжүүлсэн хөдөө аж ахуйн чиглэлийн хөрөнгө оруулалт, сан, төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт

Мал хамгаалах, тариалан эрхлэгчдийг дэмжих бодлогын хэрэгжилт, үр нөлөө хангалтгүй байна

АГУУЛГА

Тайланг бэлтгэсэн:

ҮАГ-ын Гүйцэтгэлийн аудитын газар

Захирал: Д.Ганбилэг

Аудитын менежер: Х.Баярмаа

Ахлах аудитор: Г.Цэдэнбалжир

Аудитор: Г.Гүнжидмаа
З.Ариунзаяа

Шинжээч: Л.Эрдэнэчулуун
Ц.Эрдэнэчулуун

2010 оны 7 дугаар сар

Уг тайланг ҮАГ-ын Веб сайт-аас үзнэ үү. www.mnao.mn

Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 263533 дугаарын утас, 323266 дугаарын факсаар харилцана уу.

ХАЯГ:

Үндэсний аудитын газар
210642 Чингэлтэй дүүрэг,
Засгийн газрын 4 дүгээр байр,
Бага тойруу-6, Улаанбаатар-46
Зипкод-15160
Монгол Улс

Товчилсон үгийн жагсаалт	4
Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй	5
Бүлэг 1: Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн Тариалан эрхлэлтийг дэмжих сантай холбогдсон заалтууд хэрэгжихгүй байна	
Оршил	7
Сантай холбогдох хууль, Засгийн газрын тогтоолоор баталсан журам, сайдын тушаалаар баталсан дүрэм хоорондоо зөрчилдөж байна	7
ТЭДС 2009 онд төлөвлөсөн орлогоо төвлөрүүлж чадаагүй байна	7
ТЭДС 1 тонныг нь 330.0 мянган төгрөгөөр худалдан авсан буудайг өнөөгийн зах зээлийн ханшаар борлуулахад 18.2 тэрбум төгрөгийн алдагдал хүлээхээр байна	9
Сангийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулж байна	9
Буудайн урамшууллын тогтолцоог өөрчлөх шаардлагатай байна	10
Буудайн өрийг төлөхөд зориулж төрийн өмчийг барьцаалан Голомт банкаас 5.0 тэрбум төгрөгийн зээл авчээ	12
ТЭДС-гаас зээлээр олгосон хөрөнгө хугацаандаа эргэн төлөгдөхгүй байна	13
Зээл хугацаандаа эргэн төлөгдөхгүй байгаагаас авлага их хэмжээгээр өсч, найдваргүй болох эрсдэл байна	13
ОХУ-аас импортлосон техник, тоног төхөөрөмж, үрийн буудайн төлбөрийг ТЭДС банкны зээлээр төлжээ	14
Хаврын тариалалт, уринш, ургац хураалтад зориулж зээлээр олгосон шатахууны өр төлөгдөөгүй байна	14
ОХУ, МУ-ын Засгийн газар хооронд байгуулсан хэлэлцээрийн дагуу “Эс Жи Групп” ХХК 2007 онд 40050 тонн буудайг импортлосон боловч төлбөрийг хийгээгүй байна	15
ТЭДС-гийн харъяа салбарууд буудай борлуулах, ачуулахдаа холбогдох хууль тогтоомжийг зөрчиж байна.....	15
Салбаруудын үйл ажиллагаанд тавих хяналт хангалтгүй байна	17
Дүгнэлт	18
Зөвлөмж	19

Бүлэг 2: Мал хамгаалах сангийн хөрөнгийг хуулийн дагуу зарцуулахгүй байна		Бүлэг 4: Хөрөнгө оруулалтын үр дүн тооцогдохгүй байна	
Оршил	20	Хөрөнгө оруулалтаар хийгдэх ажлууд хугацаандаа бүрэн хэрэгжээгүй байна	27
МХС-гийн орлогыг тусгайлан төлөвлөөгүй, зарцуулалтыг төлөвлөж байжээ	20	Хөрөнгө оруулалтын бодлогыг шинэчлэх шаардлагатай	28
МХС-гийн хөрөнгийг хуулийн дагуу зарцуулаагүй байна	20	Хөрөнгө оруулалтын зарцуулалтыг санхүүжилтийн гүйцэтгэлээр тайлагнаж байна ...	29
ЗГТСТ хуульд заасан судалгаа, шинжилгээний ажил МХС-д хийгдэхгүй байна	21	Хөрөнгө оруулалтын ажлыг тайлан тэнцэлд тусгах, бүртгэх талаар хангалтгүй ажиллаж байна.....	30
МХС-гийн үйл ажиллагаанд тавих хяналт хангалтгүй байна	21	Дүгнэлт	31
		Зөвлөмж	31
Дүгнэлт	22		
Зөвлөмж	22		
Бүлэг 3: ХХААХҮ-ийн салбарт хэрэгжиж буй хөтөлбөрийн үр дүн хангалтгүй байна		Холбогдох байгууллагын санал:	
Оршил	23	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас ирүүлсэн санал	32
ХХААХҮ-ийн салбарт хэрэгжиж буй төсөл хөтөлбөрүүд дэвшүүлсэн зорилтоо бүрэн биелүүлж чадаагүй байна	23	Саналд өгсөн тайлбар:	
ХХААХҮ-ийн салбарт хэрэгжиж буй төсөл хөтөлбөрүүдийн хөрөнгийг арвилан хэмнэлтгүй, үр ашиггүй, зориулалт бусаар зарцуулж байна ...	25	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны саналд өгөх тайлбар	35
“Атрын гурав дахь аян”, Жижиг дунд үйлдвэрийг дэмжих, Тариалан эрхлэлтийг дэмжих сан болон хөтөлбөрөөс бий болсон 96.1 сая төгрөгийн хөрөнгийг дансанд бүртгээгүй байна	26	ХАВСРАЛТУУД:	
		Хавсралт 11	37
Дүгнэлт	26	Хавсралт 12	38
Зөвлөмж	26		

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

ААНБ	<i>Аж ахуйн нэгж, байгууллага</i>
АНАГ	<i>Аймаг, нийслэлийн аудитын газар</i>
ЗДТГ	<i>Засаг даргын Тамгын газар</i>
ЗГТСТХ	<i>Засгийн газрын тусгай сангийн тухай хууль</i>
ОБЕГ	<i>Онцгой байдлын ерөнхий газар</i>
ОХУ	<i>Оросын Холбооны Улс</i>
БНХАУ	<i>Бүгд Найрамдах Хятад Ард Улс</i>
МХС	<i>Мал хамгаалах сан</i>
ТҮДТ	<i>Техник үйлчилгээний дундын төв</i>
ТБОНӨХБАҮХАТХ	<i>Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль</i>
ТЭДС	<i>Тариалан эрхлэлтийг дэмжих сан</i>
ХАА	<i>Хөдөө аж ахуй</i>
ХХАА	<i>Хүнс, хөдөө аж ахуй</i>
ХХААХҮ	<i>Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэр</i>
ХХААХҮЯ	<i>Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам</i>
ХХААХҮС	<i>Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд</i>
УИХ	<i>Улсын Их Хурал</i>
ҮАГ	<i>Үндэсний аудитын газар</i>

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

Аудитыг Улсын Их Хурлын Аюулгүй байдал, гадаад бодлогын Байнгын хорооны санал, Монгол Улсын Ерөнхий аудиторт Үндэсний аудитын газраас 2010 онд нийлүүлэх бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний төлөвлөгөөг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийв.

Аудитын зорилт

Улсын төсвөөс санхүүжүүлсэн хөдөө аж ахуйн чиглэлийн хөрөнгө оруулалт, сан, төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтэд аудит хийж, санал зөвлөмж боловсруулан холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдлээ.

Аудитын зорилтыг хангахын тулд дараахь чиглэлээр аудит хийлээ. Үүнд:

- Тариалан эрхлэлтийг дэмжих сангийн зарцуулалт, түүний үр дүн;
- Мал хамгаалах сангийн зарцуулалт, түүний үр дүн;
- Хөдөө аж ахуйн салбарт хэрэгжиж буй төсөл, хөтөлбөрийн үр дүн;
- Хөдөө аж ахуйн чиглэлийн хөрөнгө оруулалтын хэрэгжилт, түүний үр дүн;

Хамарсан хүрээ

Аудитад Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Мал эмнэлэг, үржлийн газар, Мал хамгаалах сан, Тариалан эрхлэлтийг дэмжих сан болон Булган, Хөтөл, Сэлэнгэ, Дархан-Уул, Орхон, Төв, Хөвсгөл, Хэнтий аймаг дахь салбар, тариалан эрхлэгч зарим аж ахуйн нэгж, гурилын үйлдвэрийг хамруулсан болно.

Арга зүй

Аудитыг гүйцэтгэхдээ Төрийн хяналт шалгалтын стандарт, түүнийг хэрэгжүүлэх аргачилсан зөвлөмж, гүйцэтгэлийн аудитын гарын авлага, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу аудитын дараахь арга зүйг ашиглав. Үүнд:

- Салбарыг дэмжсэн хөрөнгө оруулалт, сан, төсөл, хөтөлбөр, арга хэмжээг зохицуулах хууль тогтоомж, заавар, журмын хэрэгжилт, ажлын тайлагнал, салбарын мэдээ судалгаанд шинжилгээ хийх;
- Аудитад хамрагдсан байгууллагуудын холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, лавлагаа, тодруулга авах, судлах;
- Хариуцсан байгууллагын зохион байгуулсан арга хэмжээ, төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэгч, хөрөнгө оруулалтын гүйцэтгэгч сонгосон ажиллагааны талаархи материалыг түүвэрлэн судлах, тодруулга авах;
- Салбарыг дэмжсэн хөрөнгө оруулалт, сан, төсөл, хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөлт, гүйцэтгэлтэй холбогдсон санхүүгийн нотлох баримт материалд түүвэрчилсэн шалгалт, тулган баталгаажуулалт хийх;

- Тариалан эрхлэгч аж ахуйн нэгж, байгууллага, иргэдтэй уулзалт ярилцлага хийх;
- ҮАГ-аас болон бусад холбогдох газруудаас өмнө нь хийсэн аудит, салбарын үйл ажиллагаанд өгсөн үнэлгээ дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр зохион байгуулсан арга хэмжээ, түүний үр дүнг үнэлж дүгнэх;
- Цуглуулсан мэдээ судалгаанд дүн шинжилгээ, харьцуулалт хийх.

Төрийн хяналт шалгалтын стандарт, гүйцэтгэлийн шалгалтын журамд заасны дагуу аудитын дүн, дүгнэлтэд дэмжлэг болох нотлох зүйлс, холбогдох мэдээ судалгааг ажлын баримт материалд хавсаргав.

Аудитыг Гүйцэтгэлийн аудитын газрын захирал Д.Ганбилэг, менежер Х.Баярмаа нар удирдаж, ахлах аудитор Г.Цэдэнбалжир, аудитор Г.Гүнжидмаа, З.Ариунзаяа, шинжээч Ц.Эрдэнэчулуун нар хийж гүйцэтгэлээ.

Тайлангийн 1, 4 бүлгийг ахлах аудитор Г.Цэдэнбалжир, аудитор Г.Гүнжидмаа, шинжээч Л.Эрдэнэчулуун, 2, 3 дугаар бүлгийг аудитор З.Ариунзаяа, шинжээч Ц.Эрдэнэчулуун нар бичсэн бөгөөд энэ аудитад Хөвсгөл аймгийн аудитын газрын аудитор, шинжээч нар оролцсон болно.

Бүлэг 1: Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн Тариалан эрхлэлтийг дэмжих сантай холбогдсон заалтууд хэрэгжихгүй байна

Оршил

1.1 Тариалан эрхлэлтийг дэмжих сан /ТЭДС/-гийн эх үүсвэрийн зонхилох хэсгийг буцалтгүй тусламж, хандиваар бүрдүүлэхээр хуульчилсан¹ ба Засгийн газрын 2005 оны 139 дүгээр тогтоолоор “Буудай” санг “Тариалан эрхлэлтийг дэмжих сан” болгон аж ахуйн тооцооны зарчмаар зохион байгуулж, ажиллуулахаар “Тариалан эрхлэлтийг дэмжих санг бүрдүүлэх, захиран зарцуулах, түүнд хяналт тавих, тайлагнах журам”-ыг баталсан байна.

Сантай холбогдох хууль, Засгийн газрын тогтоолоор баталсан журам, сайдын тушаалаар баталсан дүрэм хоорондоо зөрчилдөж байна

1.2 УИХ “Засгийн газрын тусгай сангийн тухай хууль”-ийг 2006 оны 6 дугаар сарын 29-ний өдөр баталсан. Гэтэл Засгийн газрын 2005 оны 139 дүгээр тогтоолоор баталсан “Тариалан эрхлэлтийг дэмжих санг бүрдүүлэх, захиран зарцуулах, түүнд хяналт тавих, тайлагнах журам”, ХХАА-н сайдын /хуучин нэрээр/ 2005 оны 114 дүгээр тушаалаар баталсан “Тариалан эрхлэлтийг дэмжих сан”-гийн дүрмийг хуульд нийцүүлэн шинэчилж өөрчлөлгүйгээр мөрдөж байна.

1.3 Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 24², 32 дугаар заалтыг³ зөрчсөн дүрэм мөрдөгдөж байна. Тухайлбал,

- ТЭДС-гийн дүрэмд Мал хамгаалах, “Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл-шинэ технологи сангийн журамд заасан зориулалтаар хөрөнгө зарцуулах, өрхийн аж ахуйг хөгжүүлж, хөдөөгийн ядуурлыг бууруулахад дэмжлэг үзүүлэх, ХХАА-н салбарын хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээг санхүүжүүлэх зэрэг хуульд заагдаагүй арга хэмжээг оруулсан байна.

1.4 Түүнчлэн сангийн үйл ажиллагааг зохицуулсан журмын заалтууд ч хэрэгжихгүй байна. Үүнд:

- “Тариалан эрхлэлтийг дэмжих санг бүрдүүлэх, захиран зарцуулах, түүнд хяналт тавих, тайлагнах журам”-ын 5-д “... сангийн удирдах зөвлөлийн дарга нь Хүнс, хөдөө аж ахуйн дэд сайд байна” гэж заасан атал ХХААХҮ-ийн сайдын 2009 оны “Удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнийг батлах тухай” 98 дугаар тушаалаар Төрийн нарийн бичгийн даргыг томилон ажиллуулж байна.
- Журмын 8.3-ын “Сангийн хөрөнгөөс эргэн төлөгдөх нөхцөлөөр олгосон зээлийн ашиглалт, зарцуулалтын байдалд хяналт тавьж, зээлийг хугацаанд нь төлүүлэх ажлыг зохион байгуулах”, 11.3-ын “Сантай холбогдон үүссэн өр, авлагыг барагдуулах ажлыг зохион байгуулах”, 27.1-ийн “Сангийн сайдын зөвшөөрөлгүйгээр гадаад, дотоодын байгууллага, аж ахуйн нэгжээс зээл авах, хамтарсан үйл ажиллагаа эрхлэх”, 27.2-ын “сангийн хөрөнгийг бусдад барьцаалах, хөрөнгөөрөө бусад байгууллага, аж ахуйн нэгжид баталгаа гаргах”, 27.3-ын “санд хүлээн авсан буудайг зээлээр олгох, урьдчилгаа төлбөр хийгээгүй нөхцөлд буудайг борлуулах”, 27.5-ын “сангийн хөрөнгөөр хандив өргөх, төрөл бүрийн арга хэмжээг ивээн тэтгэх, санхүүжүүлэх” гэсэн заалтын хэрэгжилт хангалтгүй байна.

ТЭДС 2009 онд төлөвлөсөн орлогоо төвлөрүүлж чадаагүй байна

1.5 ЗГТСТ хуулийн дагуу⁴ ТЭДС-гийн орлого улсын төсөв, гадаад орон, олон улсын байгууллагаас олгосон зээл, буцалтгүй тусламж, сангийн үйл ажиллагаанаас олсон орлого, хуулиар хориглоогүй бусад эх үүсвэрээс бүрдэж байна.

¹ Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 6.1.4 дэх заалт

² Сапһаеёи аасдйи ооһаае һаһаеёи дооае бооёеёи аооаааооааао а́зёуа, Ооһаае һаһа́ азда́ззёуё, сaðóóóæò òуһуа

³ ¹òí ðóóèèéí Сòðààáòààòò азёуа, Ооһаае һаһаеёи зёе ææèèèàààíà òìðèèèò çзёе

1.6 2009 онд нийт орлогыг 23,675.4 сая төгрөгөөр төлөвлөснөөс⁵ бүгд 15,400.8 сая төгрөгийн орлого олж төлөвлөгөөт орлогын 65.0 хувийг бүрдүүлсэн бөгөөд энэ нь дотоодын болон импортлосон буудайн борлуулалт хангалтгүй байснаас шалтгаалжээ.

1.7 ТЭДС-гийн 2009 онд хүлээн авсан болон зарцуулсан нийт буудайн хөдөлгөөний тайланг авч үзвэл:

Үзүүлэлт	2008 оны буудайн		2009 оны		Нийт	
	Импортын хүнсний /ОХУ/	Дотоодын Үйлдвэрлэл	Импортын үр /ОХУ/	Дотоодын Үйлдвэрлэл		
Эхний үлдэгдэл	Хэмжээ, тн	35 895	61 924	-	-	97 819
	Үнэлгээ, м/т	15 311 696.0	24 769 532.0	-	-	40 081 228.0
Орлого	Хэмжээ, тн	-	-	5 874	119 861	125 735
	Үнэлгээ, м/т	-	-	3 889 346.0	36 606 531.0	40 495 877.0
Зарлага	Бор-лалт	Хэмжээ, тн	32 566	18 178	933	51 677
		Үнэлгээ, м/т	13 891 763.0	9 673 418.0	617 403.0	24 182 584.0
Хорогдол	Хэмжээ, тн	113	192	-	-	305
	Үнэлгээ, м/т	48 177.0	63 320.0	-	-	111 497.0
Үнийн зөрүү	Хэмжээ, тн	3 216	10 296	-	-	125 009
	Үнэлгээ, м/т	36 117.0	595 412.0	-	-	631 529.0
Эцсийн Үлдэгдэл	Хэмжээ, тн	3 216	43 554	4 942	119 861	171 573
	Үнэлгээ, м/т	1 335 637.0	14 437 382.0	3 271 943.0	36 606 531.0	55 651 493.0

1.8 2009 оны борлуулалтыг авч үзвэл:

- Дотоодын ургацын 10296.2 тонн хүнсний буудайг 3472.5 сая төгрөгөөр,
- Дотоод ургацын 7881.9 тонн үрийн буудайг 6200.9 сая төгрөгөөр,
- 2008 оны импортын хүнсний буудайн борлуулалтын үлдэгдлээс 32566.26 тонн хүнсний буудайг 13891.4 сая төгрөгөөр,
- 2008 оны импортын 933 тонн үрийн буудайг 617.4 сая төгрөгөөр борлуулжээ.

1.9 2009 оны эцсийн байдлаар 171573 тонн буюу нийт 55651.5 сая төгрөгийн буудайн үлдэгдэлтэй байгаагаас МУХС-гийн хөрөнгөөр бэлтгэсэн 80887.86 тонн, ТЭДС-гийн хөрөнгөөр бэлтгэсэн 82527.14 тонн, импортын 8158 тонн буудайн үлдэгдэлтэй байна.

1.10 МУХС-гийн тухай хууль хүчингүй болсноор УИХ-ын 2008 оны 42 дугаар тогтоол⁶, Засгийн газрын 2008 оны 58⁷, 2009 оны 92 дугаар тогтоол⁸ хууль зүйн хувьд хүчингүй болсон тул цаашид нөөц хэлбэрээр байршуулсан буудайг борлуулах, уг орлогыг улсын төсөвт төвлөрүүлэх болон ТЭДС-д ашиглуулах асуудлыг шийдвэрлэх шаардлагатай болж байна.

1.11 “Алтан тариа” ХХК, “Дархан ГТҮ” ХХК-ийн элеваторт төлбөртэй хадгалж байгаа 58446.3 тонн буудай нийт хадгалж байгаа буудайн 63.8 хувийг эзэлж байна. Хөвсгөл аймгийн Тариалан сумын агуулахад хадгалж байгаа буудайг технологийн дагуу хатаах, сэлгэх үйлчилгээ хийх боломжгүй, эрсдэл ихтэй байна. Иймд агуулахын хүчин чадлын хэмжээг тооцож нөөцлөх нь зүйтэй юм.

Аж ахуйн нэгжийн нэр	2008 оны ургацын	2009 оны ургацын	Импорт	Нийт Хэмжээ	Тайлбар
Улаанбаатар ХХК	5 562.1		376.0	5 938.1	Төлбөргүй
Алтан тариа ХХК	2 289.1	17 064.5		19 353.6	1 тонн буудайн хоногын хөлс 75 төг
Хангай ХХК	3 000	3 831.6	1 530.0	8 361.6	Төлбөргүй

⁴ Санхүүжилтийн агууламж 2008 оны 12 сарын 31-ийн төлөвлөгөөний 7.2 дүгээр хэсэг

⁵ Үндэсний төсвөөс: Өмчлөхийн үйлдвэрлэлийн хөрөнгө 2009 оны 12 сарын 31-ийн төлөвлөгөө

⁶ Монгол Олсыг хөгжүүлэх сангийн хөрөнгийн зарим хэсгийг хүнсний буудайн нөөц хэлбэрээр байршуулах тухай”

⁷ “Иргэдийн төлөөлөгчдийн Их Хурлын 2008 оны 58 дугаар тогтоол, Өмчлөхийн үйлдвэрлэлийн хөрөнгө, Өмчлөхийн үйлдвэрлэлийн хөрөнгө, Өмчлөхийн үйлдвэрлэлийн хөрөнгө, Өмчлөхийн үйлдвэрлэлийн хөрөнгө, Өмчлөхийн үйлдвэрлэлийн хөрөнгө”

⁸ “Монгол Улсыг хөгжүүлэх санд 2008 оны 92 дугаар тогтоол, Өмчлөхийн үйлдвэрлэлийн хөрөнгө, Өмчлөхийн үйлдвэрлэлийн хөрөнгө, Өмчлөхийн үйлдвэрлэлийн хөрөнгө, Өмчлөхийн үйлдвэрлэлийн хөрөнгө”

Дархан ГТҮ ХХК	4 058.4	33 729.4	1 304.9	39 092.7	1 тонн буудайн хоногын хөлс 55 төг
Хөвсгөл ГТҮ ХХК		5 281.8		5 281.8	Төлбөргүй
Гачуурт ХХК	13 590.3			13 590.3	Төлбөргүй
Дүн	28 499.9	59 907.3	3 210.9	91 618.1	

ТЭДС 1 тонныг нь 330.0 мянган төгрөгөөр худалдан авсан буудайг өнөөгийн зах зээлийн ханшаар борлуулахад 18.2 тэрбум төгрөгийн алдагдал хүлээхээр байна

1.12 2008-2009 онд худалдан авсан дотоодын ургацын үлдэгдэл 166328 тонн буудайг зах зээлийн үнээр борлуулахад 18.2 тэрбум төгрөгийн алдагдал хүлээх тооцоо гарч байна.

Хүнсний Буудай	Хэмжээ	Буудайн өртөг		Өнөөгийн зах зээлийн үнэ		Алдагдал
		Үнэ	Дүн	Үнэ	Дүн	
Импортын буудай	3 211	426 569	1 369 627 745	220 000	706 376 000	663 251 745
2009 оны дотоод	119 862	305 411	36 607 020 577	220 000	26 369 530 000	10 237 490 577
2008 оны үлдэгдэл	43 556	388 667	16 928 779 852	220 000	9 582 320 000	7 346 459 852
Дүн	166 628		54 905 428 174		36 658 226 000	18 247 202 174

1.13 Үүнд дараахь хүчин зүйл нөлөөлж байна:

- 2009 оны Гадаад худалдааны барааны статистик мэдээллээр 2008 онд 171293.2 тонн буудай, 132874.9 тонн гурил, 2009 онд 114728.9 тонн буудай, 105716.0 тонн гурил тус тус дотоодын зах зээл дээр импортлосон байна.
- 2010 оны 6 дугаар сарын 1-ний өдрийн байдлаар 53606.6 тонн буудай, 40874.2 тонн гурилыг импортлосон байна.⁹ Өөрөөр хэлбэл хямд үнэтэй, татваргүй буудай, гурил оруулж байна.

1.14 2009 оны байдлаар улсын хэмжээгээр буудайн болон гурилын хэрэгцээ, хангамжийн байдлыг хүн амын тоонд харьцуулан үзэхэд 317.25 мянган тонн байсан бөгөөд тухайн онд 406.3 мянган тонн буудай

Буудай, гурилын хэрэгцээ хангамжийн судалгаа

Үзүүлэлт /хэмжих нэгж/	2007 он	2008 он	2009 он	2010 оны төсөөлөл
Хүн ам /мян.хүн/	2 643,1	2 689,8	2 727,6	2 765,7
Физ.норм /кг/	91,25	91,25	91,25	91,25
Хэрэгцээт буудай /мян.тн/	307,42	312,85	317,25	321,68
Хэрэгцээт гурил /мян.тн/	221,16	225,07	228,24	231,42
Хураасан буудай /мян.тн/	118,4	200,0	406,3	428,9

хураасан нь дотоодын ургацаар хэрэгцээг хангаж чадахаар байна. Гэтэл ТЭДС 2009 онд 114728.9 тонн буудай, 105716.0 тонн гурил импортлосноос дотоодын үр тариа борлогдохгүй, тариалан эрхлэгчдээс урьдчилан авсан буудайн төлбөр, гадаад болон дотоодын зээлийн төлбөрийг төлж чадахгүйд хүрч байна.

1.15 ҮСХ-оос гаргасан тариалан эрхлэлт, гол нэрийн бүтээгдэхүүний нийлүүлэлтийн статистик мэдээллээс үзэхэд дараахь зүйл ажиглагдаж байна. (Хавсралт 11)

Сангийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулж байна

1.16 ТЭДС-гийн 2008 оны батлагдсан төсөвт зардал 34229.8 сая төгрөг, гүйцэтгэлээр 32429.9 сая төгрөг байна. Гэвч дараахь зардлуудыг хэтрүүлж зарцуулсан байна. Үүнд:

- 2008 онд ОХУ-аас 100.0 мянган тонн буудай, 15.0 мянган тонн гурил, Энэтхэг улсаас тусламжийн элсэн чихэр, цагаан будааг хүлээн авч тараах ажил төлөвлөгдөөгүйгээс цалин, нийгмийн даатгалын зардал 168.5 сая төгрөг, тээвэр шатахууны зардал 95.5 сая төгрөг, дотоод томилолтын зардал 17.0 сая төгрөг, бүгд 249.3 сая төгрөгөөр хэтэрчээ.
- Мөн эд хогшил худалдан авах зардал 55.2 сая төгрөг, төлбөр хураамж, татварын зардал 33.3 сая төгрөгөөр хэтэрчээ.

⁹ Үгс 2010.06.06: Үгсээс бусад бусад үгсүүд нь 2010 оны 5 сарын 6-ны өдөр

- Төвлөрсөн арга хэмжээний зардлыг 9605.8 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 10195.6 сая төгрөг зарцуулж 589.8 сая төгрөгөөр хэтэрсэн нь Атар-3 аяны үндэсний хөтөлбөр батлагдсантай холбоотой байна.
- 2008 онд Төсвийн ерөнхийлөн захирагч болон сангийн удирдах зөвлөл, сангийн ажилагсдад 173.4 сая төгрөгийн төлөвлөгдөөгүй урамшил шагнал олгосон байна.

1.17 2009 онд нийт орлогын төлөвлөгөөг 8274.6 сая төгрөгөөр тасалдуулсан нь 6431.8 сая төгрөгөөр зардлыг бууруулжээ. Гэвч дараахь зардлыг хэтрүүлэн зарцуулжээ. Үүнд:

- 2009 онд төлөвлөсөн 23 нэр төрлийн зардлаас 13-ыг нь хэтрүүлж, төлөвлөгдөөгүй 8 төрлийн зардал нэмж санхүүжүүлсэн.
- Түүнчлэн 2009 онд батлагдсан төсвөөс цалин, нийгмийн даатгалын зардлыг 76.3 сая, гэрэл цахилгааны зардлыг 27.8 сая, тээвэр шатахууны зардлыг 32.2 сая, шуудан холбооны зардлыг 10.5 сая, бичиг хэргийн зардлыг 9.0 сая, дотоодын томилолтын зардлыг 22.1 сая, эд хогшил худалдан авах зардлыг 28.8 сая, төлбөр хураамжийн зардлыг 179.3 сая, урсгал засварын зардлыг 51.3 сая төгрөгөөр тус тус хэтрүүлэн зарцуулжээ.
- 2009 онд 5215.0 сая төгрөгийн төлөвлөгдөөгүй зардал гарчээ. Тухайлбал, ажиллагсдад олгосон урамшуулалд 53.8 сая төгрөг, хоолны зардалд 9.9 сая төгрөг, ОХУ-аас техник, тоног төхөөрөмж, буудай нийлүүлэх ажлыг зохион байгуулахад 454.2 сая төгрөг, өмнөх оны буудайн төлбөрт 4697.1 сая төгрөг гарчээ.
- Төрийн өмнөөс гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөрт 17724.8 сая төгрөг төлөвлөж, 11522.4 сая төгрөг зарцуулсан нь буудайн борлуулалт хийгдээгүй, орлого тасарсантай холбоотой байна.
- Буудайн урамшуулалд 11360.0 сая төгрөг олгохоос, 4959.5 сая төгрөгийг зарцуулсан байна. Үлдэх хэсгийг он дамжиж олгосон байна.

1.18 ТЭДС-гийн хөрөнгөөс 2008-2009 онд нийт 252.1 сая төгрөгөөр ХХААХҮЯ-ны төвлөрсөн арга хэмжээний зардлыг санхүүжүүлсэн байна.

1.19 ХХААХҮ-ийн салбарын хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгаагүй арга хэмжээг ТЭДС-аас санхүүжүүлж байна.

1.20 ХХААХҮ-ийн сайдын 2009 оны 175, 274 дүгээр тушаалаар ХХААХҮЯ-ны өргөтгөлийн барилгын ажлыг ТЭДС-гаас санхүүжүүлэхээр шийдвэрлэн 2009 онд 317.5 сая төгрөг, 2010 оны 5 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 669.0 сая төгрөг, нийт 986.5 сая төгрөг зарцуулсан байна.

1.21 2006-2010 онд ТЭДС-гийн үйл ажиллагаанд хамаарахгүй ХХААХҮЯ-ны гадаад, дотоод томилолтын зардалд 142.4 сая төгрөг, яамнаас зохион байгуулсан хурал, зөвлөгөөн, хүлээн авалт, бусад зэрэг төвлөрсөн арга хэмжээний зардалд 242.4 сая төгрөг, бүгд 384.8 сая төгрөгийг санхүүжүүлсэн байна.

1.22 ТЭДС-гийн хөрөнгөөс ХХААХҮ-ийн сайдын 2009 оны 112 дугаар тушаалаар Төв аймгийн Баянчандмань сумын Доргонтын эхэн дэх амралтын барилгын цахилгааны шугамын холболтын ажлын зураг төсөвгүй, сонгон шалгаруулалт явуулалгүйгээр 16.3 сая төгрөгийг “Цэлмэг ази” ХХК-д, зам, талбайн барилгын ажилд 17.2 сая төгрөгийг “Цүүрдэн” ХХК-д тус тус шилжүүлсэн байна.

Буудайн урамшууллын тогтолцоог өөрчлөх шаардлагатай байна

1.23 Хүнс, хөдөө аж ахуйн болон Сангийн сайдын 2007 оны 110/266 дугаар тушаалаар баталсан “Хүнсний буудайн үйлдвэрлэлийг дэмжих, урамшууллын

хөрөнгийг зарцуулах, түүнд хяналт тавих, тайлагнах журам”-ын 2.7 дахь заалт¹⁰ мөрдөгдөхгүй байна.

1.24 ТЭДС улсын төсвөөс 2007 онд 3953.2 сая төгрөг, 2008 онд 11,164.0 сая төгрөгийн санхүүжилт авч тариалан эрхлэгчдэд буудайн урамшуулал олгосон байна.

1.25 2009 онд аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд 11,360.0 сая төгрөгийн урамшуулал төлөвлөж, ХХААХҮ-ийн сайдын 2009 оны 297, 291 дүгээр тушаалаар 10,499.7 сая төгрөгийн урамшуулал олгож, үлдэх 860,3 сая төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлэлгүй 2009 онд худалдан авсан буудайн төлбөрт зарцуулжээ.

1.26 2008 онд газар тариалангийн үйлдвэрлэл эрхэлдэг 23 аж ахуйн нэгж өөрийн гурилын үйлдвэртээ 13.2 мянган тонн буудай нийлүүлж байсан бол 2009 онд 34 аж ахуйн нэгж 28.4 мянган тонн буудай нийлүүлж урамшуулал авчээ. Гэвч зарим аж ахуйн нэгж, байгууллага өөрийн харьяа гурилын үйлдвэртээ буудай нийлүүлсэн нь баримтаар бүрэн нотлогдохгүй байна. Тухайлбал:

Орхон аймагт:

- “Хостав” ХХК, “Алтан тошлой” ХХК-ийн гурилын үйлдвэрт нийлүүлсэн буудайг өдөр өдрөөр бүртгэлгүй дүнгээр нь нэг акт бичсэн байна. Үйлдвэрлэлд оруулахдаа жинэлсэн баримтгүй учраас, хэдий хэмжээний буудай авсан нь бүрэн нотлогдохгүй байна.

Сэлэнгэ аймагт:

- Зүүнхараа дахь “СББ” ХК 12 аж ахуйн нэгж, байгууллагаас 7878,5 тн буудай авч 989 тн гурил үйлдвэрлэж, 6400 тн буудайн үлдэгдэлтэй гэсэн тооцоог гаргаж өгсөн бөгөөд буудайны үлдэгдлийг ойролцоогоор тооцож үзэхэд 700 гаруй тн буудай спиртийн элеваторт хийсэн байна.

Энэ бүгдээс үзэхэд гурилын үйлдвэрт гэж авсан буудайг спирт хийхэд зарцуулж байгаа бөгөөд тус үйлдвэрт буудай нийлүүлсэн гэж урамшуулал авсан компаниудын 720 тн буудайг спирт үйлдвэрлэсэн гэж тооцоход хамгийн багадаа 57,6 сая төгрөгийн урамшуулал илүү олгогдсон тооцоо гарч байна.

1.27 Зарим аж ахуйн нэгж, байгууллага хуурамч баримт бүрдүүлэн буудайн урамшуулал авсан нь аудитын явцад илэрлээ. Тухайлбал,

Булган аймагт:

- Булган аймгийн Хутаг-Өндөр сумын тариалан, мал аж ахуй эрхэлдэг “Мэргэн хөтөл” ХХК-д “Мэдээлэл аудит” ХХК-ний Булган дахь салбар /захирал Сэвжидмаа/-т 91,8 тн буудай нийлүүлсэн гэж 7,3 сая төгрөгийн хууль бус баримт бүрдүүлж урамшуулал авсан байна. Булган аймгийн Тэшиг сумын “Шинэ амжилт” ХХК-иас Хутаг-Өндөр сумын “Гурван борхуд” ХХК-ийн гурилын үйлдвэрт 98,3 тн буудай нийлүүлсэн гэж 7,8 сая төгрөгийн урамшууллыг хууль бус баримтаар авсан байна.

Сэлэнгэ аймагт:

- Сэлэнгэ аймгийн Баруунбүрэн сумын “Энх бүрэн-Өндөр” ХХК /захирал Амарсайхан/ 2008 онд 60 га талбайд буудай тарьж 60 гаруй тн хураасан буудайгаа өр авлагаа барагдуулахаар тарааж өгсөн байна. Гэтэл тус компани 2008 онд 302,5 тн буудайг Улаанбаатар хотын “Хөх таана” хоршоонд тушаасан гэж 24,2 сая төгрөгийн урамшууллыг Хадгаламж банкинд өөрийн нэрийн хувийн харилцах дансаар дамжуулан авсан байна.

Орхон аймагт

- 2008 онд Оргилдэлгэр ХХК-иас Орхон дэнж ХХК-д 247,8 тн хүнсний буудай нийлүүлсэн гэж 19.8 сая төгрөг авсан боловч гурилын үйлдвэр сүүлийн 2 жил огт ажиллаагүй, хуурамч баримтаар 19.8 сая төгрөгийн урамшуулал авсныг тус компаниар төлүүлж, төсвийн орлого болгох нь зүйтэй гэж үзлээ.

Хөвсгөл аймагт

“Хөвсгөл Алтан дуулга” ХК цэвэр жингээр биш ачуулсан буудайгаар тооцож 521.8 тн буудайд 26.1 сая төгрөг, мөн 2009 оны хаврын тариалалтад хэрэглэсэн 433.9 тн буудайд

¹⁰ Урамшууллын хөрөнгийг буудай үйлдвэрлэгчдээс дотоодын гурилын үйлдвэр, тариалан эрхлэлтийг дэмжих санд нийлүүлсэн хүнсний буудайд урамшуулал олгоход зориулан зарцуулна.

“Сангийн хөрөнгийг бусдад барьцаалах, хөрөнгөөрөө бусад байгууллага, аж ахуйн нэгжид баталгаа гаргах” зэрэг хориглосон заалтыг зөрчсөн байна. Зээл авахыг зөвшөөрсөн Сангийн сайдын албан ёсны баримт алга байна. Хууль, журам зөрчсөн холбогдох ажилтнуудад хариуцлага тооцож, энэ зөрчлийг давтан гаруулахгүй байх нь зүйтэй гэж үзлээ.

ТЭДС-гаас зээлээр олгосон хөрөнгө хугацаандаа эргэн төлөгдөхгүй байна

1.31 ТЭДС-гийн Удирдах зөвлөл эргэн төлөх нөхцлөөр олгосон зээлийн ашиглалт, зарцуулалтад хяналт тавьж, хугацаанд нь төлүүлэх ажил зохион байгуулаагүй байна.

1.32 2009 онд 132 аж ахуйн нэгж, иргэнд нийт 11708.4 сая төгрөгийн гэрээ хийн 1912.1 сая төгрөгийн урьдчилгаа төлбөрийг төлүүлэн ХАА-н техник, тоног төхөөрөмжийг олгосон бөгөөд 157.2 сая төгрөгийн төлбөр ондоо төлөгдөөгүй байна.

1.33 2006-2009 онд буудайн үр, шатахуун зээлээр авсан 44 аж ахуйн нэгж, иргэдэд 2243.9 сая төгрөг, сүү боловсруулах загвар үйлдвэр байгуулах төслийн шалгаруулалтад тэнцсэн аж ахуйн нэгж, иргэдэд олгосон 125.0 сая төгрөг, 2004-2007 онд төлөгдсөн байх шинэ технологийн сангийн 178.7 сая төгрөгийн зээл тус тус хугацаандаа барагдаагүй байна.

Зээл хугацаандаа эргэн төлөгдөхгүй байгаагаас авлага их хэмжээгээр өсч, найдваргүй болох эрсдэл байна

1.34 ТЭДС-гийн 2009 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаарх 38,9 тэрбум төгрөгийн авлагын 97.1 хувь буюу 37.9 тэрбум төгрөгийг 1000 гаруй аж ахуйн нэгж, байгууллагын, 3.1 хувь буюу 1.2 тэрбум төгрөгийг 320 гаруй иргэдээс авах авлага эзэлж байна. Тухайлбал,

- “Милл хаус” ХХК ТЭДС-гаас хүнсний буудайг урьдчилгаа төлбөргүйгээр зээл авч, гурил үйлдвэрлэн борлуулсан орлогоос буудайн төлбөрийг төлж байна. Тус компани 2010 оны 6 дугаар сарын 1-ний байдлаар 3245.1 сая төгрөгийн өрийн үлдэгдэлтэй гарч байна.
- “Барил трейд” ХХК-д 2010 оны 3 дугаар 15-нд 10/01 дүгээр гэрээгээр 1000 тн буудай зээлээр олгосон боловч төлбөрийг графикайн дагуу төлөөгүй байна.

1.35 Нийт авлагын 20.9 тэрбум төгрөг буюу 53.7 хувь хугацаа хэтэрсэн, 2009 онд 226 аж ахуйн нэгж, байгууллага, иргэд 17.8 тэрбум төгрөгийн авлагын үлдэгдэлд тооцоо нийлж, 21.1 тэрбум төгрөгт тооцоо нийлээгүй байна.

/сая.төг/

Үзүүлэлт	2009 он	2008 он	2007 он	2007 оноос өмнөх	Нийт
Үрийн буудай	3 811.3	817.2	436.9		5 065.4
Хүнсний буудай	7 934.7				7 934.7
Гербицид, бордоо	157.9	10.7	26.4		195.0
Төмсний иж бүрдэл	210.7	74.0			284.7
ХАА-н техник	3 314.9	1 274.8			4 589.7
Хүлэмж	13.6				13.6
Атар III	234.1	504.9			739.0
“Сүү” төсөл		467.0			467.0
Хөрөнгө оруулалт	677.1				677.1
Импортын техник, тоног төхөөрөмж	4 131.8				4 131.8
Шатахуун	3 321.4				3 321.4
Техник үрлүүр			42.8		42.8
“Жимс” төсөл	850.0				850.0
Бусад	1 059.6	307.4	535.3	2 696.9	4 599.2
Байгууллагаас авах авлага	6 146.1				6 146.1
Салбаруудаас авах авлага	41.2				41.2
Тодорхойгүй авлагын хасагдуулга	(100.8)				(100.8)
Дүн	31 803.6	3 456.0	1 041.4	2 696.9	38 997.9

Нийт авлагын 13000,1 сая төгрөг буюу 33,3 хувь нь хүнсний болон үрийн буудайн, 8721,5 сая төгрөг буюу 22,3 хувь нь хөдөө аж ахуйн техник хэрэгслийн, 3321,4 сая төгрөг буюу 8,5 хувь нь шатахууны, 7205,7 сая төгрөг буюу 18,5 хувь нь 2009 онд үүссэн байгууллагаас авах авлага, 3539,6 сая төгрөг буюу 9,1 хувь нь 2007, 2008 он буюу түүнээс өмнөх онуудад үүссэн авлага байна.

ОХУ-аас импортлосон техник, тоног төхөөрөмж, үрийн буудайн төлбөрийг ТЭДС банкны зээлээр төлжээ

1.36 ТЭДС ХАА-н техник, тоног төхөөрөмжийг зээлээр худалдан авахдаа “Тариалан эрхлэлтийг дэмжих санг бүрдүүлэх, захиран зарцуулах, түүнд хяналт тавих, тайлагнах журам”-ын 27.1, “Тариалан эрхлэлтийг дэмжих сангийн дүрэм”-ийн 42.1 дэх заалтуудыг¹² зөрчиж удирдах зөвлөлийн хуралдаанаар гүйцэтгэх захиралд эрх олгосон байна.

1.37 Төлбөрийг Худалдаа хөгжлийн банктай 2009 оны 4 дүгээр сарын 29-ний өдөр гэрээ байгуулж, 11571.6 мянган ам.долларын зээлийн эх үүсвэрээр санхүүжүүлсэн байна.

- Дээрх шийдвэрийн хүрээнд нийт 13037.2 мянган ам.долларын 7 гэрээгээр 10802.1 мянган ам.долларын үнэ бүхий 14 нэрийн 389 ширхэг газар тариалангийн үйлдвэрлэлийн техник, тоног төхөөрөмж, 2083.4 мянган ам.долларын өртөг бүхий 5208.65 тн үрийн буудай, 151.6 мянган ам.долларын 544 тн хүнсний буудай авчээ.
- ХХААХҮ-ийн сайдын 2009 оны 143 дугаар тушаалаар техник, тоног төхөөрөмжийн урьдчилгаа төлбөрийг худалдах үнийн дүнгийн 15-20 хувиар тооцон, жилийн 13 хувийн зээлийн хүүтэй, 3 жилийн хугацаатай лизингийн гэрээгээр борлуулахаар шийдвэрлэсэн байна.

1.38 Худалдаа хөгжлийн банкаас авсан зээлийн өрийн үлдэгдэл 2009 оны жилийн эцсийн байдлаар 9357.7 мянган ам.доллар байна.

Хаврын тариалалт, уринш, ургац хураалтад зориулж зээлээр олгосон шатахууны өр төлөгдөөгүй байна

1.39 Засгийн газрын 2009 оны 133 дугаар тогтоолыг үндэслэн ХХААХҮ-ийн сайдын 106 дугаар тушаалын дагуу ХХААХҮЯ, ОБЕГ-ын хооронд гэрээ байгуулж хаврын тариалалт болон уриншийн ажилд зориулан 1105 аж ахуйн нэгж, иргэдэд 2.9 мянган тонн 4.2 тэрбум төгрөгийн шатахуун зээлээр олгожээ.

1.40 ХХААХҮ-ийн сайдын 2009 оны 138, 216 дугаар тушаалаар уринш боловсруулалтын 2 дугаар ээлж болон ургац хураалтад зориулан 1298 аж ахуйн нэгж, байгууллага, иргэнд 5.0 мянган тонн 6.0 тэрбум төгрөгийн шатахуун зээлээр олгосон байна. Тендер зарлалгүйгээр “НИК” ХК-тай шууд гэрээ хийж гүйцэтгүүлсэн байна.

1.41 Зээлээр олгосон нийт 10.3 тэрбум төгрөгөөс оны эцэст тариалан эрхлэгчдээс 7.0 тэрбум төгрөгийн 21.3 мянган тонн буудайг зээлийн өрөнд авч, 3.3 тэрбум төгрөгийн өрийг аж ахуйн нэгжүүдээс бүрэн төвлөрүүлээгүй, шатахууныг эргэн байршуулаагүй байна.

¹² /ᠢᠨᠲᠤᠨᠢᠨᠲᠤ 27.1, ᠠᠵᠢᠨᠠᠢᠨᠲᠤ 42.1 /ᠠᠶᠤ ᠴᠠᠠᠭᠠᠭᠤᠨᠢ “ᠨᠠᠢᠠᠭᠠᠭᠠᠨᠠᠭᠤᠨ ᠴᠠᠠᠭᠠᠭᠠᠭᠠᠨ ᠴᠠᠠᠭᠠᠭᠠᠭᠠᠨ, ᠠᠢᠨᠠᠡᠨᠠᠨᠠᠨᠠᠨ ᠠᠠᠭᠠᠭᠠᠭᠠᠭᠠᠨ, ᠠᠠᠭᠠᠭᠠᠭᠠᠭᠠᠭᠠᠨ ᠢᠵᠠᠭᠠᠭᠠᠨ ᠴᠠᠠᠭᠠᠭᠠᠭᠠᠨ, ᠳᠠᠢᠨᠠᠨᠠᠨᠠᠨ ᠵᠢᠭᠡ ᠠᠠᠭᠠᠭᠠᠭᠠᠭᠠᠨ ᠶᠠᠭᠠᠭᠠᠭᠠᠨ”

ОХУ, МУ-ын Засгийн газар хооронд байгуулсан хэлэлцээрийн дагуу “Эс Жи Групп” ХХК 2007 онд 40050 тонн буудайг импортлосон боловч төлбөрийг хийгээгүй байна

1.42 Монгол Улс болон ОХУ-ын Засгийн газар хооронд 2006 оны 7 дугаар сард “Хүнсний улаан буудай нийлүүлэх тухай” хэлэлцээр байгуулж 40050 тонн хүнсний буудай авахаар болжээ.

1.43 Засгийн газар хоорондын гэрээ хэлэлцээрийн дагуу дараахь үйл ажиллагаа хийгджээ. Үүнд:

- ХХААХҮЯ-наас “Эс Жи Групп” болон “Пайонеринг интернешнел” ХХК-иудын консерциумыг шалгаруулсан боловч эдгээр компаниуд нь ТБОНӨХБАҮХАТХ-ийг зөрчиж, гэрээг ХХААХҮЯ болон ТЭДС-тай бус ОХУ-ын хүнсний буудай нийлүүлэгч байгууллагатай шууд гэрээ байгуулж, буудайг дотоодын зах зээлд борлуулсан,
- Гэтэл хэлэлцээрийн 4 дүгээр зүйлд заасан Монголын тал буудайн төлбөрт 2009 оны 10 дугаар сарын 18-ны өдрөөс 11 дүгээр сарын 8-ны хооронд 3,724,6 мянган ам.долларыг төлөх заалт хэрэгжээгүй, төлбөр хийгдээгүй,
- Буудайн төлбөр графикт хугацаанаас 2010 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар 252 хоногоор хэтэрч 257.2 мянган ам.долларын алдангийн хамт нийт 3,981.8 мянган ам.долларын төлөгдөөгүй өртэй байна.

1.44 Энэхүү төлбөрөөс ТЭДС-д тушаасан 682,4 тн буудайн төлбөр болох 102,2 мянган ам.долларыг ТЭДС-гаас, үлдэх 3,849,0 мянган ам.долларыг “Эс Жи Групп, “Пайонеринг интернешнел” ХХК -иар төлүүлэх нь зүйтэй гэж үзлээ.

ТЭДС-гийн харъяа салбарууд буудай борлуулах, ачуулахдаа холбогдох хууль тогтоомжийг зөрчиж байна

1.45 Улсын төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн хүнсний буудайн борлуулалт, ачилтын үйл ажиллагаанд доорх зөрчил гарч байна. Тухайлбал,

- ХХААХҮЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга Т.Гантулга баталгаажуулсан, ТЭДС-гийн гүйцэтгэх захирал Ц.Батсайхан, “Милл хаус” ХХК-ийн гүйцэтгэх захирал нар байгуулсан 2009 оны 9 дүгээр сарын 3-ны өдрийн гэрээгээр ТБОНӨТ хуулийн 30 дугаар зүйлийн 3¹³, “Тариалан эрхлэлтийг дэмжих санг бүрдүүлэх, захиран зарцуулах, түүнд хяналт тавих, тайлагнах журам”-ын 27.3 дахь заалтуудыг¹⁴ зөрчиж зээл олгосон байна.

1.46 Сэлэнгэ салбар

- Тус салбараас иргэн С.Эрдэнийн нэр дээр бүгд 8 вагоноор 500 тн буудайг ачуулсан боловч, албан ёсны зарлагын баримт үйлдээгүй, салбарын 2007 оны санхүүгийн тайлан тэнцэлд тусгаагүй байна.
- 2007 онд ачуулсан 500 тн буюу 125.0 сая төгрөгийн буудайг Сэлэнгэ буудай ХХК-аас авлагаар тусгаж, нөхөн төлүүлэн, байгууллагыг хохиролгүй болгох нь зүйтэй гэж үзлээ.
- Тус салбарын нягтлан бодогчоор ажиллаж байсан Б.Бямбажав удирдлагын албан ёсны зөвшөөрөлгүйгээр 2007 оны 10 дугаар сард 2 вагон буудайг ачуулж, 30.0 сая төгрөгийг төлж барагдуулсан ч албан тушаал, эрх мэдлээ ашиглан байгууллагын хөрөнгөөр бизнес хийжээ.
- Сэлэнгэ салбараас 2008 оны 10 дугаар сарын 8-ны өдөр 2 вагон 120 тн буудайг Зүүнхараагийн “СББ” ХК-д ачуулж буудайн төлбөр бүгд 53,7 сая төгрөгийг Сэлэнгэ салбарын даргаар ажиллаж байсан Доржханд бэлнээр хүлээн авчээ. Үүнийг тодруулахад мөнгийг “Сэлэнгэ буудай” ХХК-ийн захирал М.Шинэчулуун өөрөө авсан гэж тайлбар гаргав.
- “Сэлэнгэ буудай” ХХК нь “СББ” ХК-д худалдан борлуулсан дээрх буудайн орлогыг санхүүгийн тайланд тусгаагүй байлаа.

¹³ “Орлоогийг ашигтай илүү ирдөггүйг үйлдэхийг зорьж 30 аргаар нь үйлдэхийг зорьж...орлоогийг өргөсний үр дүнд үйлдэхийг зорьж ашигтай илүү ирдөггүйг үйлдэхийг зорьж 30 аргаар нь үйлдэхийг зорьж...”

¹⁴ “наага үйлдэхийг зорьж ашигтай илүү ирдөггүйг үйлдэхийг зорьж...”

1.47 Хөтөл салбар

а. ТЭДС 2006 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр Бэрэн групп ХХК-д буудайн үнэ 100.0 сая төгрөг шилжүүлжээ. Салбарын нярав Очгэрэл Булган ХХК-иас 2006 оны 12 дугаар сарын 8-ны өдөр хорогдол тооцолгүй, 476 тн буудайг орлогод авч тайланд тусгасан боловч, хүлээлгэн өгсөн хүний гарын үсэггүй, акт үйлдэгдээгүй байна.

Лабораторын эрхлэгч Д.Алтаннавчийн тодорхойлсноор 476 тн буудай нийлүүлээгүй байна.

Мөн “Гурил тэжээл Булган” ХК буудай нийлүүлээгүй талаар тодорхойлолт гаргасан болно. Өөрөөр хэлбэл дээрх буудай нь Хөтөл салбарт тушаагдаагүй байна.

б. Хөтөл салбараас дээрх буудайг ТЭДС-гийн дарга Ч.Пэрэнлэйн шийдвэрээр иргэн Батсуурьт 66,9 тн, “Эх гам” ХХК буюу иргэн Батсуурьт 200,0 тн, иргэн Лхагваад (Эх гам ХХК) 209,1 тн, бүгд 476 тн буудайг зарлага болгосон боловч дээрх иргэдэд олгогдоогүй байна.

Эх гам ХХК болон иргэд буудайн үнэ 104720.0 мянган төгрөгийг ТЭДС-гийн Зоос банк дахь дансанд дараахь байдлаар тушаасан байна. Үүнд:

- 2007.10.05 Хөтөл салбарт “Эх гам” ХХК-иас тушаасан 200 тн буудайн үнэ 44,000,0 мянган төгрөгийг тус салбараас
- 2007.10.16 “Эх гам” ХХК 209,1 тн буудайн үнэ 46,000,0 мянган төгрөг
- 2007.11.02 иргэн Батсуурь 66,9 тн буудайн үнэ 14,720,0 мянган төгрөг тушаажээ.

ТЭДС 476 тн буудайг авахдаа 1 тн-ыг 210,0 мянган төгрөгөөр, худалдахдаа 220,0 мянган төгрөгөөр тооцжээ.

3 вагон буудайн талаар

2007 оны 8 дугаар сарын 16-ны өдөр Жем интерншнл ХХК-д ачигдсан гэх буудай нь Хөтөл салбарын бүртгэлд байхгүй бөгөөд салбарын захирал асан Ч.Гантулга өөрийн хувийн компаниас тушаасан буудайнаас цэвэрлэгээгээр гарсан буудайг (хорогдол тооцсон) ачуулсан байна. Уг буудайг дараахь байдлаар тушаасан байна. Үүнд:

- Мөн “Эх гам” ХХК-иас 2006 оны ургацаас тушаасан 250,42 тн буудайнаас лабораторийн шинжилгээний хорогдлоор 39.025 тн-ыг буудайг хасч, товарын буудайд 211.395 тн
- Сэлэнгэ аймгийн Баруунбүрэн сумын “Ивэн түрүү” ХХК-иас 2007 оны ургацаас тус салбарт 573.76 тн буудай тушааснаас лабораторийн хорогдлоор 131.4 тн буудайг хасч товарын буудайд 442.36 тн
- Сэлэнгэ аймгийн Орхон сумын “Эх гам” ХХК-иас 2007 оны ургацаас Хөтөл салбарт 322.14 тн буудай тушааснаас лабораторийн шинжилгээний хорогдлоор 28,05 тн буудайг хасч 294.09 тн буудайг тус тус товарт тэнцүүлж орлогод авчээ.

“Эх гам”, “Ивэн түрүү” ХХК-иас бүгд 1146.32 тн буудай тушааснаас 198.475 тн буудайг лабораторийн хорогдлоор тооцож, 947.845 тн буудайг товарт тэнцүүлэн хүлээн авсан акт үйлдэж, захирал Ч.Гантулга, санхүүч Т.Нарангэрэл, лаборант Д.Алтаннавч, буудай тушаагч Б.Баттогтох, Ш.Халтар нар гарын үсэг зурсан байна.

Салбарын захирал асан Ч.Гантулга эрх мэдлээ ашиглаж өөрийн компанийн тушаасан буудайнаас цэвэрлэж, дамжуулан ачсан боловч уг зардал болох 720,0 мянган төгрөгийг (180,0 тн х4000) тушаасан баримт 2007 оны касс, харилцахын баримтад алга байна.

8 вагон буудайн талаар

Хөтөл салбараас 2007 оны 1 дүгээр сарын 4-ний өдөр 6 вагоноор, 4 дүгээр сарын 24-ний өдөр Д.Ганбатын нэр дээр 2 вагоноор ачигдсан буудай нь тус салбарын ачигдсан буудайн бүртгэлд байхгүй, харин Хөтөл өртөөний журналд тэмдэглэгдсэн байна.

Тус салбарын нягтлан бодогч асан Т.Нарангэрэл 2010 оны 4 дүгээр сарын 30-ны өдөр “2007 оны 1 дүгээр сарын 4-ний өдөр УБТЗ-ын Хөтөл өртөөний замаар ТЭДС-гийн Хөтөл салбараас УБ хот руу Жем интерншнл ХХК-ийн 6 вагон, иргэн Д.Ганбатын 2 вагон буудайг 2007 оны 4-р сарын 24-ний өдөр дамжуулан ачсан байна” гэсэн тодорхойлолт гаргасан.

ТЭДС-гийн Хөтөл салбарын 2007 оны 1 дүгээр сарын 4-ний өдрийн кассын орлогын баримтанд Жи Эм ХХК-иас Буудай дамжуулсан ажиллагааны зардалд 660,000 төгрөгийг Ц.Болд, 2007 оны 4 дүгээр сарын 9-ний өдөр “GM” ХХК-ийн Ганбатаас вагон пүүний төлбөрт 125,000 төгрөгийг тус тус тушаасан байна.

“Жем интернэшнл” компаний 2010 оны 5 дугаар сарын 13-ны өдрийн албан бичгээр 660 тн буудай хүлээн авсан тайлбар гаргасан.

Салбаруудын үйл ажиллагаанд тавих хяналт хангалтгүй байна

1.48 ТЭДС-гийн орон нутаг дахь салбар нэгжийн үйл ажиллагаанд багагүй зөрчил дутагдал гарч байна. Тухайлбал,

1. Сангийн сайдын 2005 онд баталсан “Менген кассын дүрэм”-ийг мөрдөж ажиллахгүй байна.
 - ТЭДС-ийн менген касс гэнэтийн тооллого хийхэд албан ёсны бус баримтаар зарлага болгосон, бусдад тэр хугацаагаар олгосон зэргээр 7000,0 мянган төгрөг дутагдсаныг аудитын явцад баримтыг нь бийрүүлэн төлүүлж барагдуулсан.
 - Менген хөрөнгийн тайлан, түүний орлого зарлагын баримтад хянаж, шалгасан хэний гарын үсэг байхгүй, менген хөрөнгийн үлдэгдлийг тоолж тооцоог бодсон акт ТЭДС болон аль ч салбарт байсангүй.
 - Сэлэнгэ салбарын нягтлан бодогч Галхүү менген кассын гүйлгээнд бүртгэлээр хяналт тавиагүйгээс харилцах данснаас чекээр бэлнээр авсан 3 удаагийн гүйлгээгээр бүгд 194.3 сая төгрөгийг кассын тайланд оруулалгүй, баримтгүй шууд зарлага болгож, дараа нь нөхөн бүрдүүлсэн.
 - Сэлэнгэ салбарт ажиллагсдын илүү цагийн хөлсийг зохих шийдвэргүй үндсэн цалингаас 2 дахин тооцож олгосон, амралтын цалинг тооцох хоногийг тушаалаар батлахгүй зөвхөн тэдний өдрөөс амрана гэсэн тушаал гаргасан, кассын баримтын бүрдэл хангалтгүй байв.
2. Хөтөл салбар шатахууны тооцоог хийгээгүй, тоолуур хэмжих хэрэгсэлгүй, баримтын бүрдэлгүй зарлага болгож байжээ. Нярав Б.Буяндаваагийн шатахууны тооцоог шалгахад 2036 л орчим түлш илүүдэлтэй гарсан болно.
3. Булган салбарт шатахууны зарлага болгохдоо тоолуур байхгүйгээс баримжаагаар тооцож байвал зохих хэмжээнээс 520 л шатахуун илүү гарч байна.
4. Буудайн тооллогыг ТЭДС-гийн салбаруудад баримжаалах аргаар тооцоход дараахь байдалтай байв. Үүнд:
 - Булган салбар ТЭДС-ийн цэвэр жингээр тооцсон буудайн үлдэгдэл 30,956 тн байна. Салбарын удирдлага энэ буудайнаас 18,017 тн нь цэвэрлэгдээгүй учраас буудайн технологийн үйл явцын дүнд гарах хаягдал хорогдлын хамт хэмжигдэж байна гэж тайлбарлав.
 - Хөтөл салбарт 92 селос болон одыг дээрх маягаар хэмжиж тооцож үзэхэд 30,513 тн буюу байвал зохих үлдэгдлээс 572,6 тн дутагдахаар тооцоо гарч байна.
 - Сэлэнгэ салбарт дээрх маягаар салбарын селос, Алтан тариа ХХК, Гачуурт ХХК-д хадгалагдаж буй буудайнд хэмжилт хийхэд 14045 тн буудай байх ёстой хэмжээнээс 284,6 тн буудай дутахаар байна.

Селосонд байгаа буудайг бүрэн хоосолж байж, үнэн зөв тоо гарах учраас тоо хэмжээг бодитой тогтоох боломж шалгалтын явцад байсангүй.

Дүгнэлт:

- ТЭДС-гийн үйл ажиллагааг зохицуулж буй холбогдох хууль, Засгийн газрын тогтоолоор баталсан журам, сайдын тушаалаар баталсан дүрмийн заалтууд хоорондоо зөрчилдөж байна.
- ТЭДС-гийн тайлангаар 2009 оны эцэст 171.5 мянган тонн буудайн үлдэгдэлтэй байхад буудай, гурил импортлож байгаагаас тариалан эрхлэгчдээс худалдан авсан буудай борлогдохгүй, буудайн төлбөр төлөгдөхгүйд хүрч, улмаар уг буудайг өнөөгийн ханшаар борлуулахад ихээхэн хэмжээний алдагдал хүлээх болж байна.
- ТЭДС-гаас эргэн төлөгдөх нөхцөлөөр олгосон ХАА-н техник, тоног төхөөрөмж, шатахуун, хүнсний болон үрийн буудайн төлбөрийг барагдуулах ажил хангалтгүйгээс 2009 оны жилийн эцсийн тайлан тэнцлээр өмнөх онуудаас хуримтлагдсан 38.9 тэрбум төгрөгийн авлагын 53.7 хувь нь хугацаа хэтэрсэн байна.
- МУХС-гийн тухай хууль, УИХ-ын болон Засгийн газрын тогтоол хууль эрх зүйн хувьд хүчингүй болж, МУХС-гийн хөрөнгөөр нөөц хэлбэрээр бэлтгэж, байршуулсан буудайг борлуулах, орлогыг улсын төсөвт төвлөрүүлэх, ТЭДС-д ашиглуулах эсэх асуудлыг шийдвэрлэх шаардлагатай байна.
- Сангийн удирдлага Сангийн сайдын зөвшөөрөлгүйгээр байгууллага, аж ахуйн нэгжээс зээл авах, хамтарсан үйл ажиллагаа эрхлэхийг хориглосон холбогдох журмыг зөрчиж, төрийн өмч хөрөнгийг барьцаалан Голомт банкнаас 5.0 тэрбум төгрөгийн зээл авчээ.
- МУХС-гаас 2009 онд тариалан эрхлэгчдэд олгох урамшууллын үлдэгдэл 860.3 сая төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлэлгүй сангийн үйл ажиллагаанд зарцуулжээ.
- ТЭДС 357.1 сая төгрөгийн урамшууллыг Төсвийн ерөнхийлөн захирагч, удирдах зөвлөлийн гишүүд, Сангийн удирдлага, ажилтнуудад хавтгайруулан олгож төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан байна.
- Төсвийн тухай хууль, салбарын хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдаагүй ХХААХҮЯ-ны өргөтгөлийн барилгын ажлыг ТЭДС-гаас санхүүжүүлсэн байна.
- 2006-2010 онд ТЭДС-гаас ХХААХҮЯ-ны гадаад, дотоод томилолт, яамнаас зохион байгуулсан хурал, зөвлөгөөн, хүлээн авалт, бусад зардлыг санхүүжүүлсэн байна.
- ТЭДС-гийн салбаруудын үйл ажиллагаанд хүнсний болон тэжээлийн буудайг анхан шатны болон нягтлан бодох бүртгэлд тусгалгүйгээр зарлага болгох, өр авлага үүсгэх, мөнгөн кассын дүрмийг мөрдөхгүй байх, шатахууны орлого зарлагыг үнэн зөв тайлагнаагүй, буудайг хадгалах, хорогдол тооцох, технологийн дагуу сэлгэлт, хэмжилт хийх ажилд тавих хяналт хангалтгүй байна.
- ТЭДС-гийн салбаруудын селос агуулахад хадгалагдаж байгаа буудайг хэмжих, жигнэх боломжгүйгээс нягтлан бодох бүртгэлээр байвал зохих үлдэгдэлтэй тохирч байгаа эсэхийг баталгаажуулж чадахгүй байна.

Зөвлөмж:**Монгол Улсын Ерөнхий сайд С.Батболдод:**

- Тариалан эрхлэлтийг дэмжих сангийн одоогийн бүтэц зохион байгуулалтыг өөрчлөн үйл ажиллагааг нь оновчтой хэлбэрээр зохион байгуулах, Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд дээрх сантай холбоотой заалтад өөрчлөлт оруулах асуудлыг судалж, зохих журмын дагуу шийдвэрлүүлэх,
- Эх орны тариалан эрхлэх үйл ажиллагааг дэмжих чиглэлээр тухайн жилийн ургацын байдалтай уялдуулан импортын буудай, гурилын хэмжээг оновчтой тогтоох, татварын бодлогоор зохицуулалт хийх арга хэмжээ авч байх,
- МУХС-гийн хөрөнгөөр бэлтгэсэн буудайг борлуулж, орлогыг улсын төсөвт төвлөрүүлэх болон ТЭДС-д ашиглуулах эсэх асуудлыг шийдвэрлэх.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Т.Бадамжунайд:

- Тариалан эрхлэгчдэд олгож байгаа буудайн урамшууллыг цаашид олгох эсэх асуудлыг судлаж шийдвэрлэх,
- Сангийн хөрөнгөөр яамны удирдлага, сангийн удирдах зөвлөл болон ажилтнуудад урамшуулал олгохыг зогсоох,
- Яамны төвлөрсөн арга хэмжээ, гадаад дотоод томилолт, сургалт семинар, бусад зардлыг сангийн хөрөнгөөр санхүүжүүлэхийг зогсоох,
- ХХААХҮЯ-ны өргөтгөлийн барилга угсралтын ажлын санхүүжилтийг зохих журмын дагуу шийдвэрлүүлэх, сангаас авсан хөрөнгийг эргүүлэн бүрдүүлэх,
- Зөрчил дутагдал гаргасан холбогдох албан тушаалтнуудад хариуцлага тооцох,

Тариалан эрхлэлтийг дэмжих сангийн захирал Л.Дүйнхэржавт:

- Буудайг хадгалах, сэлгэх, хатаах, цэвэрлэх технологийг сайжруулах, түүнтэй холбогдох хорогдлын норм, нормативыг шинэчлэх, силос, шатахууны савыг хэмжилзүйн хуулийн дагуу мэргэжлийн байгууллагаар баталгаажуулж ажиллах,
- Тариалан эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгийг бусдад зээлдүүлэх, яамны төвлөрсөн арга хэмжээ, бусад төсөл хөтөлбөрт зарцуулахыг зогсоох,
- Хуримтлагдсан өр, авлагыг барагдуулах ажлыг эрчимжүүлэх, найдваргүй авлагыг хууль хяналтын байгууллагад шилжүүлж шийдвэрлүүлэх,
- ТЭДС-гийн Хөтөл, Сэлэнгэ салбаруудын селос агуулахад хадгалагдаж байгаа хүнсний болон үрийн буудайн үлдэгдэлд тооллого хийх,
- Салбаруудын үйл ажиллагаанд тавих хяналтыг сайжруулах.

Бүлэг 2: Мал хамгаалах сангийн хөрөнгийг хуулийн дагуу зарцуулахгүй байна

Оршил

2.1 Мал хамгаалах сан нь 2001 онд Мал сүргийг ган, зудаас хамгаалахад туслах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор байгуулагдан Засгийн газрын мөн оны 246 дугаар тогтоолоор батлагдсан “Мал хамгаалах сан бүрдүүлэх, захиран зарцуулах, тайлагнах журам”-ыг мөрдөж ирсэн байна. 2006 онд “Засгийн газрын тусгай сангийн тухай” хууль гарснаас хойш энэ хуулийн хүрээнд үйл ажиллагаа явуулж байна. Уг сан 2009 оны 8 дугаар сар хүртэл Тариалан эрхлэлтийг дэмжих сангийн харьяанд ажиллаж байгаад ХХААХҮ-ийн сайдын 2009 оны 84 дүгээр тушаалаар Мал хамгаалах санг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Мал эмнэлэг, үржлийн газрын даргын эрхлэх асуудлын хүрээнд шилжүүлсэн байна.

МХС-гийн орлогыг тусгайлан төлөвлөөгүй, зарцуулалтыг төлөвлөж байжээ

2.2 Мал хамгаалах санд 2005-2006 онд нийт 1593.4 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 2090.8 сая төгрөг зарцуулжээ.

2.3 МХС-гийн орлого нь улсын төсөв болон ХХААХҮ-ийн салбарт хэрэгжиж байгаа хөтөлбөрийн зээлийн буцаан төвлөрүүлэлтээс бүрддэг байна. Тухайлбал, 2001 онд Мал сүргийг ган зудаас хамгаалах хөтөлбөрийн хүрээнд аймгуудын ЗДТГ-т олгосон өвсний нөөц бүрдүүлэх зээлийн буцаан төвлөрүүлэлт, ЗГТСТ хуулийн дагуу улсын төсвөөс олгох хөрөнгө, “Шилмэл хээлтүүлэгч дэд хөтөлбөр”, “Эрчимжсэн мал аж ахуйг дэмжих хөтөлбөр”, аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд олгосон зээлийн буцаан төвлөрүүлэлт, “Малын тэжээл” хөтөлбөрөөс тэжээлийн цехийн тоног төхөөрөмжийн зээлийн эргэн төлөлтөөс бүрдэж байна.

2.4 МХС-гийн орлого ЗГТСТ хуульд заасан эх үүсвэрээс¹⁵ бүрдээгүй байна. МХС-д зээлдэгчээс төлөх өрийн судалгаа хийгдэж байгаагүйгээс тус санд орох жилийн орлогыг бүрэн, үнэн зөв тодорхойлж чадахгүй байна.

МХС-гийн хөрөнгийг хуулийн дагуу зарцуулаагүй байна

2.5 ЗГТСТ хуулийн 23.1 дэх заалтыг зөрчиж сангийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулжээ. Тухайлбал,

- Сангаас 2005-2009 онд сайн малчны шагнал, алтан төлийн эзэн зэрэг шагнал урамшуулалд 25.3 сая төгрөг, 2005 онд яамны засварын ажилд 28,0 сая төгрөг, 2009 онд сүү хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ хийх, томилолт, бичиг хэргийн зардалд 6.9 сая төгрөгийг тус тус зориулалт бусаар зарцуулсан,
- Засгийн газрын 2001 оны 246 дугаар тогтоолоор батлагдсан “Мал хамгаалах сан бүрдүүлэх, захиран зарцуулах, тайлагнах журам”-ын дагуу мал хамгаалах сангаас аж ахуйн нэгж, иргэнд 2001-2006 оны 6 дугаар сарын 29-ийг хүртлэх хугацаанд зээл олгосон, харин 2006 оны Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд мал хамгаалах сангаас аж ахуйн нэгж, иргэнд зээл олгох талаар тусгагдаагүй байна.
- ЗГТСТ хуульд мал хамгаалах сангийн төвлөрсөн хөрөнгөөс зээл олгох заалт тусгагдаагүй байхад 2007-2009 онд аж ахуйн нэгж байгууллага, иргэнд нийт 418.0 сая төгрөгийн хүүгүй мөнгөн зээл олгосон,
- “Баянчандмань тур” ХХК 2007-2009 онд махны чиглэлийн хонь, сүүний үхрийн эрчимжсэн аж ахуй байгуулахаар гэрээ байгуулж 2009 онд мал хамгаалах сангаас 48,0 сая төгрөгийг Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын “Сэлэнгэ төгөлдөр” ХХК-ны нэрээр, 128,0 сая төгрөгийг

¹⁵ Үйлдвэр, аж ахуйн үйлчилгээний үйлдвэр, аж ахуйн үйлчилгээний үйлдвэр 7 дугаар зүйлэ зааснаар гадаадын тусламжийн мөнгөн хөрөнгө, тоног төхөөрөмж, бараа материал, бусад эд зүйлс, гадаад улс, олон улсын байгууллага, түүнчлэн гадаад, дотоодын аж ахуйн нэгж, байгууллага, иргэнээс өгсөн буцалтгүй тусламж, хандив, тусгай сангийн үйл ажиллагаанаас олсон орлого, бусад эх үүсвэр

өөрийн компанийн нэрээр, Төв аймгийн ЗДТГ-ын Мал аж ахуйн газраас 50,0 сая төгрөгийн зээлийг тус тус авсан байна.

- Тус компани тухайн эрчимжсэн аж ахуйг байгуулаагүй зөвхөн мал худалдан авч орон нутгийн иргэдэд гэрээгээр эзэмшүүлж, зээлийг зориулалт бусаар зарцуулсан,
- Сэлэнгэ аймгийн иргэн Б.Пүрэвсүрэн 2006 оны 3 дугаар сард мал хамгаалах сангаас үхрийн фермерийн аж ахуй байгуулах зорилгоор 13,5 сая төгрөгийн зээл авсан боловч уг төслөө хэрэгжүүлээгүй, өөр зүйлд зарцуулж, зээлээ төлөөгүй,
- Улаанбаатар хотын иргэн М. Батсүрэн 2006 онд 14,0 сая төгрөг, Төв аймгийн иргэн Ц.Тунгалаг 2007 онд 10,0 сая төгрөг, Завхан аймгийн Тосонцэнгэл сумын иргэн Г.Төрмөнх 2008 онд 11,0 сая төгрөгийн зээл авсан боловч төслөө хэрэгжүүлээгүй, зээл төлөгдөөгүй хугацаа хэтэрчээ.

2.6 МХС-гийн 2005-2009 оны зарцуулсан нийт 2090.8 сая төгрөгийн 22.8 хувь буюу 478.4 сая төгрөгөөр ЗГТСТ хуульд заагдаагүй арга хэмжээг санхүүжүүлжээ.

ЗГТСТ хуульд заасан судалгаа, шинжилгээний ажил МХС-д хийгдэхгүй байна

2.7 ЗГТСТ хуулийн 23 дугаар зүйлийн 23.1.1-д заасан судалгаа, шинжилгээний ажлыг хийгээгүй байна. Тухайлбал,

- МХС-гаас малын бэлчээрийн даацыг тодорхойлох, мал оторлон өвөлжүүлэхтэй холбогдсон томоохон өгөөжтэй судалгааны ажил хийсэн эсэх нь тодорхойгүй, зөвхөн томилолт, шатахууны зардал, тракторын иж бүрдэл, тэжээлийн үнэ, зөвлөмж боловсруулах зэрэг ажлыг санхүүжүүлсэн,
- Мал өсгөх тодорхой тооцоо судалгаа байхгүй, цөөн тооны аж ахуй нэгж, иргэдэд дэмжлэг үзүүлж зээл олгосон,
- Мал аж ахуйн хөгжлийн үр шим, үр өгөөжийг хэрхэн тооцох талаар тодорхой судалгаа, шинжилгээ хийгдээгүй байна.

МХС-гийн үйл ажиллагаанд тавих хяналт хангалтгүй байна

2.8 Эргэн төлөгдөх нөхцөлөөр олгосон зээлийн өрийг барагдуулах, зээлийн ашиглалтад тавих хяналт хангалтгүй байна. Тухайлбал,

- 2001-2009 онд 208 аж ахуйн нэгж, иргэнд 2767,4 сая төгрөгийн хүүгүй зээл олгосноос 2001 онд мал сүргийг ган зудаас хамгаалах хөтөлбөрийн хүрээнд 19 аймгийн Засаг даргын Тамгын газарт өвсний нөөц бүрдүүлэхээр олгосон 965,5 сая, аж ахуйн нэгж, иргэнд олгосон 554,3 сая төгрөгийн зээлийн хугацаа хэтэрч төлөгдөөгүй,
- МХС-аас 2009 онд зээлийн үлдэгдлийг барагдуулах ажилд зориулан 5,5 сая төгрөгийг зарцуулсан боловч дөнгөж 9,9 сая төгрөгийн авлагыг барагдуулсан ба авлагын судалгаа зөрүүтэй. Үүнд: Нийслэл болон 19 аймгийн ЗДТГ-т мал сүргийг ган зудаас хамгаалахад туслах үндэсний хөтөлбөрийн хүрээнд аймгуудад өвсний нөөц бүрдүүлэх зорилгоор олгосон хадлангийн зээлийн 965,5 сая төгрөгийн зээлийг Сангийн яамны Төрийн сангийн газрын өрийн удирдлагын хэлтсийн авлагын данстай давхардуулан бүртгэж, тайлан тэнцэлд тусгасан. 2007 оны 5 дугаар сарын 1-нд ХХААС-ын 61 дүгээр тушаалаар Мал хамгаалах сангаас 180.0 сая төгрөгийн зээлийг аж ахуйн нэгж, иргэнд олгохоор тушаал гарч зээл олгогдсон байхад Эрчимжсэн мал аж ахуйн хөтөлбөрөөс гэрээгүйгээр зээл олгосноор гаргасан,
- МХС-аас “ПРАЙМЛАЙНС” ББСБ-аар дамжуулан олгож байсан хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэл 30,5 сая төгрөг, 2003-2005 онд авсан Төв аймгийн Эрдэнэ, Баяндэлгэр, Жаргалан сум, Багануур, Налайх дүүрэг, Гачуурт тосгоны 10 аж ахуйн нэгж, иргэний 28,4 сая төгрөг, нийт 58,9 сая төгрөгийн хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдлийг сангийн дансанд төвлөрүүлэхээр албан шаардлага өгсөн болно.
- Малыг удмын сангийн үндэсний төвийн “Шилмэл хээлтүүлэгч” хөтөлбөрийн хүрээнд саалийн фермерийн аж ахуй бий болгох, үржлийн мал бойжуулах зориулалтаар 2003 онд авсан 9,0 сая төгрөгийн зээлийг Шүүхийн шийдвэргүйгээр ХХААХҮС-ын 2008 оны 12 дугаар сарын 30-ний өдрийн 74 дүгээр тушаалаар чөлөөлсөн,
- МХС-гаас олгосон зээлийн эргэн төлөлт, ашиглалтанд тавих дотоодын хяналт хангалтгүйгээс их хэмжээний зээлийн хугацаа хэтэрч, зарим хариуцагч тодорхойгүй байна. Тухайлбал: МХС-гаас 2001-2009 онд авсан 25 аж ахуйн нэгж, 3 иргэн 411,4 сая төгрөгийн зээл, зээлийн гэрээ, холбогдох баримт материалууд алга байна. Мөн “ПРАЙМЛАЙНС”

ББСБ-аар дамжуулан 2005-2008 онуудад олгосон зээлээс 21 иргэний 116,9 сая төгрөгийн зээлийн хугацаа хэтэрч, эргэн төлөгдөх найдваргүй болсон байна.

2.9 МХС-гийн зээлийн асуудлыг хариуцсан мэргэжилтэн 2-3 удаа солигдсоноос шалтгаалан зээлийн эргэн төлөлтийн асуудал удаашралтай байна.

Дүгнэлт:

- Мал хамгаалах сангийн, орлогыг урьдчилан төлөвлөөгүй, зөвхөн зарцуулалтыг төлөвлөж байжээ.
- ЗГТСТ хуульд заасан судалгаа, шинжилгээний ажил мал хамгаалах санд хийгдэхгүй, үйл ажиллагаанд тавих хяналт хангалтгүй байна

Зөвлөмж:

ХХААХҮ-ийн сайд Т.Бадамжунайд:

- Мал хамгаалах сангийн хөрөнгийг хуулийн дагуу зориулалтын арга хэмжээнд зарцуулах, Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд заасны дагуу Засгийн газрын 2001 оны 246 дугаар тогтоолоор батлагдсан “Мал хамгаалах сан бүрдүүлэх, захиран зарцуулах, тайлагнах журам”-ыг шинэчлэх,
- Мал хамгаалах сангийн үйл ажиллагаанд зөрчил дутагдал гаргасан холбогдох албан тушаалтанд хариуцлага тооцох,

Улсын мал эмнэлэг, үржлийн газрын дарга П.Дамдиндоржид:

- Мал хамгаалах сангийн орлогыг үндэслэлтэй төлөвлөх, хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулах,
- Сангаас олгосон зээлийн өрийн үлдэглийг барагдуулах ажлыг үр дүнтэй зохион байгуулах.

Бүлэг 3: ХХААХҮ-ийн салбарт хэрэгжиж буй төсөл, хөтөлбөрийн үр дүн хангалтгүй байна

Оршил

3.1 ХХААХҮ-ийн салбарт өнөөгийн байдлаар дотоодын 22 хөтөлбөр хэрэгжиж байна. Үүнээс: мал аж ахуйн салбарт 6, газар тариалангийн салбарт 2, хүнсний салбарт 6, хөнгөн үйлдвэрийн салбарт 8 хөтөлбөр хэрэгжиж байна. Эдгээр хөтөлбөрүүд 1999-2016 он хүртэл 1-4 үе шаттай хэрэгжсэн бөгөөд 2009 онд “Үхэр, хонь, ямааны бруцеллөз өвчинтэй тэмцэх” хөтөлбөр хэрэгжиж дуусчээ.

3.2 ХХААХҮ-ийн салбарт хэрэгжиж буй хөтөлбөрийг чиглэлээр нь үзүүлбэл:

1	Салбар	Хэрэгжих хугацаа	Төсөвт өртөг	2005-2009 төлөвлөгөө	2005-2009 гүйцэтгэл	зөрүү
1	Мал аж ахуй	2002-2015	89500.0	36029.7	41050.5	5020.7
2	Хүнс	2001-2016	70859.9	3471.7	2907.1	-577.6
3	Газар тариалан	2005-2012	83705.7	76063.6	72966.2	-3097.4
4	Хөнгөн үйлдвэр	2001-2016	68870.7	62958.5	35480.5	-27478.0
Нийт дүн			312936.4	178523.5	152404.3	-26132.2

3.3 “Хөтөлбөр батлах тухай” Засгийн газрын 2009 оны 32 дугаар тогтоолоор “Хүнсний хангамж, аюулгүй байдал, хоол тэжээл хөтөлбөр”-ийг хүчингүй болгож, “Хүнсний баталгаат байдал” үндэсний хөтөлбөрийг баталжээ. Тус хөтөлбөрт 2009 онд хөрөнгө төсөвлөгдөөгүй учир “Хүнсний хангамж, аюулгүй байдал, хоол тэжээл хөтөлбөр”-ийн санхүүжилтийн үлдэгдэл 13.0 сая төгрөгийг зарцуулахаар ХХААХҮ-ийн сайдын 2009 оны 81 дүгээр тушаалаар баталж зарцуулжээ.

3.4 2005-2009 онд ХХААХҮ-ийн салбарт хэрэгжиж буй хөтөлбөрүүд нийт 312.9 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй бөгөөд үүнээс 178.5 тэрбум төгрөг төсөвлөж, 152.4 тэрбум төгрөгийг санхүүжүүлжээ.

ХХААХҮ-ийн салбарт хэрэгжиж буй төсөл хөтөлбөрүүд дэвшүүлсэн зорилтоо бүрэн биелүүлж чадаагүй байна

3.5 ХХААХҮ-ийн салбарт дотоодын эх үүсвэрээр хэрэгжиж буй зарим хөтөлбөр дэвшүүлсэн зорилтоо хангаж чадахгүй байна. Тухайлбал,

- “Эрчимжсэн мал аж ахуйн хөгжлийг дэмжих” хөтөлбөрийн хүрээний 1 дүгээр шатанд бэлчээрийг өмчлүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлэх асуудал бүрэн шийдвэрлэгдээгүй, фермерийн статусыг эрх зүйн хувьд тодорхойлох ажил хийгдээгүй, зээлтэй холбоотой эрх зүйн орчинг бүрдүүлээгүй байхад зээл олгосон,
- “Эрчимжсэн мал аж ахуйн хөгжлийг дэмжих” хөтөлбөр 2005, 2006 онд аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд олгосон мөнгөн зээл болон эргэн төлөгдөх мал, амьтны, зарим гэрээ байхгүй,
- Тус хөтөлбөрөөр 2005-2009 онд нийт 2509,7 сая төгрөгийн зээл олгосноос мөнгөн хэлбэрээр 2494,7 сая төгрөг, машин техник, тоног төхөөрөмжийн зээл хэлбэрээр 98,7 сая төгрөг, барилга, засварын ажилд зээл хэлбэрээр 85,0 сая төгрөг олгосон,
- “Эрчимжсэн мал аж ахуйн хөгжлийг дэмжих” хөтөлбөрийн зээлийн эргэн төлөгдөх үйл ажиллагаанд хяналт хангалтгүй байна. Тус хөтөлбөр 2005-2009 онд 2494,7 сая төгрөгийн хүүгүй мөнгөн зээл олгосноос 88,4 сая төгрөгийн зээлийн хугацаа хэтэрч найдваргүй зээлд бүртгэгдсэн,
- “Малын чанар сайжруулах” хөтөлбөрийн хүрээнд гадаадаас өндөр ашиг шимт мал импортлон оруулж ирэх, дотооддоо үр, үржлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх зорилт хангалтгүй хэрэгжсэн,
- “Сүү” хөтөлбөр нь хэрэгжээд 3 жил болж байгаа боловч “Хүнсний тухай” хуульд өөрчлөлт

оруулах ажил удаашралтай байна. Хөтөлбөр хэрэгжих хугацаанд дэмжлэг үзүүлсэн аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд ямар үр өгөөж гарч байгаа талаар нарийвчилсан судалгаа алга байна. Улсын төсвөөс уг хөтөлбөрт нийт 1419,3 сая төгрөг олгогдсоноос мөнгөн зээлд 917,0 сая төгрөг, тоног төхөөрөмжид 448,8 сая төгрөг, сургалт сурталчилгаанд 50,3 сая төгрөг зарцуулсан боловч тодорхой үр дүн гараагүй байна,

- “Экологийн цэвэр бүтээгдэхүүн” хөтөлбөрийн мониторингийн дүгнэлтэй танилцахад энэ хөтөлбөрийн үр дүн хангалтгүй гэж дүгнэжээ. ХХХААХҮЯ-ны санхүүгийн хэлтсээс гаргаж өгсөн 2007-2009 оны гүйцэтгэлийн судалгаанаас үзэхэд хөтөлбөрийн санхүүжилтийн дийлэнхийг хөтөлбөрт холбогдолгүй зүйлд зарцуулсан байна,
- “Иод дутлын эмгэгтэй тэмцэх” 3 дахь шатны хөтөлбөрийн гол зорилго нь хүн амыг чанартай, аюулгүй иоджуулсан үндэсний үйлдвэрлэлийн давсаар хангах хэмжээг нэмэгдүүлж, хэрэглээг тогтмолжуулан хэвшүүлэх зорилтыг дэвшүүлсэн боловч хэрэгжээгүй нь импортын давсаар хангагдсантай холбоотой байна.

3.6 Хөнгөн үйлдвэрийн салбарт хэрэгжиж байгаа 8 хөтөлбөрийн хөрөнгийн эх үүсвэр хугацаандаа олгогдохгүй байгаагаас зарим арга хэмжээ бүрэн хэрэгжихгүй байна. Тухайлбал, “Ноос дэд” хөтөлбөр хэрэгжээд 10 жил болж байгаа боловч ноосны ашиглалтыг сайжруулж, шинэ нэрийн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх ажил хийгдээгүй.

3.7 2005-2009 онд ХХААХҮ-ийн салбарт хэрэгжиж буй хөтөлбөрүүд Улсын төсвөөс нийт 75.1 тэрбум төгрөг төлөвлөж гүйцэтгэлээр 71.1 тэрбум төгрөгийг зарцуулсан, хөрөнгө оруулалтаар 89.1 тэрбум төгрөгийг төлөвлөж 66.6 тэрбум төгрөгийг зарцуулсан байна. (Хөтөлбөрийн судалгааг хавсралт 12-т үзүүлэв)

3.8 Хөнгөн үйлдвэрийн салбарт 2005-2009 онд төсөл хөтөлбөрийн арга хэмжээнд улсын төсвөөс 35480,5 сая төгрөг зарцуулж, үүнээс “Жижиг дунд үйлдвэрийг дэмжих” хөтөлбөрөөс 33000,0 сая төгрөгийн зээлийг тус тус аж ахуйн нэгжид олгожээ. Хөнгөн үйлдвэрийн машин техник, тоног төхөөрөмжид зориулан 25.5 сая төгрөгийг дэмжлэг хэлбэрээр олгосон байна. Гэвч хөнгөн үйлдвэрийн салбарт хэрэгжиж буй хөтөлбөрийн үр өгөөж, үр дүнг тооцох явдал хангалтгүй байна. Тухайлбал,

- “Оёмол бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг хөгжүүлэх” хөтөлбөрийн хүрээнд үндэсний үйлдвэрүүдийн үйл ажиллагааг уялдуулсан менежментийн судалгаа, үйлдвэрлэлийн үр ашгийг дээшлүүлсэн, бүтээмжийн өсөлтийг нэмэгдүүлсэн үр дүнг тооцоогүй,
- “Ноос” дэд хөтөлбөрийн хүрээнд ноосны салбарын өнөөгийн байдал, дэлхийн ба дотоодын зах зээлийн эрэлт нийлүүлэлт, үйлдвэрүүдийн хүчин чадлын ашиглалт, тогтвортой ажиллагааг хангахад нөлөөлөх хүчин зүйлсийг тооцсон эсэх тодорхойгүй байна.

3.9 МАА-н салбарт 2005-2009 онд улсын төсвөөс 40.3 тэрбум төгрөг зарцуулсан байна. Үүнээс мөнгөн зээлд 2,8 тэрбум төгрөг, дэмжлэгээр 3.1 тэрбум төгрөгийг зарцуулжээ. Машин техник хэрэгсэл, тоног төхөөрөмжид 171.0 сая төгрөг, малын вакцинжуулалтад 33.9 тэрбум төгрөг зарцуулсан байна. МАА-н салбарт хэрэгжиж буй төслийн үр өгөөжийг авч үзвэл:

- МАА-н салбарт хэрэгжүүлж байгаа хөтөлбөрийн хүрээнд зээл, дэмжлэг үзүүлж байгаа боловч түүнээс гарах үр өгөөж нь бага, тухайн зээл бэлчээрийн болон суурин мал аж ахуй эрхэлж байгаа аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн зөвхөн өрхийн хэрэгцээг хангах түвшинд байгаа тул хүн амын хүнсний хэрэгцээг хангахад нөлөө үзүүлж чадаагүй байна.

3.10 МАА-н салбарт хэрэгжиж буй хөтөлбөрийн үр дүн улс орны хэмжээнд бус орон нутгийн тодорхой хэсэг бүлэг хүмүүст хүрсэн байна.

3.11 “Атрын гурав дахь аян”-д нийт 78,8 тэрбум төгрөг төлөвлөж, 2008-2009 онд 71.6 тэрбум төгрөг зарцуулснаас машин тоног төхөөрөмж авахаар 36.1 тэрбум төгрөг олгож, 2517 аж ахуйн нэгж, иргэнд шатахууны дэмжлэг болгон 5.4 тэрбум төгрөгийг

зарцуулж, 610 аж ахуйн нэгж, иргэнд 9.4 тэрбум төгрөгийн үрийн будаа олгож, услалтын системд 8.7 тэрбум төгрөг зарцуулсан байна.

3.12 Засгийн газраас “Атрын гурав дахь аян” хөтөлбөр зарлан тариалангийн үйлдвэрлэлийг сэргээж, хэрэгцээт үр тариагаа 100 хувь дотоодоос хангах зорилт тавьж ажиллаж байгаа хэдий ч дотоодын үйлдвэрлэлийг хамгаалсан бодлогогүй, тариалан эрхлэгчдийн бүтээгдэхүүнийг борлуулах нөхцөл бүрдээгүй байна. Тухайлбал,

- Хөтөлбөрийн үйл ажиллагаа үр тарианы үйлдвэрлэлийг дэмжихэд илүү анхаарснаас хүнсний ногооны үйлдвэрлэл нэмэгдээгүй, 2009 онд хурааж авсан ургацын хэмжээ 2008 оноос буурсан,
- Хөтөлбөрийн хүрээнд 300.0 мянган га талбайд хөрсний төлөв байдлын судалгаа хийгдэхээс 178.0 мянган га талбай хамрагдсан,
- Хөрсний үржил шимийг дээшлүүлэх, нэгжээс авах ургацын хэмжээг нэмэгдүүлэх зорилгоор био бордооны үйлдвэрлэлийг дэмжихэд хөрөнгө зарцуулаагүй байна.
- Хөтөлбөрийн хүрээнд Засгийн газрын 2008 оны 136 дугаар тогтоолоор “Агропарк” төслийг 334 сум, дүүрэгт хэрэгжүүлэхээр нийт 3,8 тэрбум төгрөгийг төсөвлөн бага оврын трактор, хүлэмж, зоорь байгуулах байснаас бага оврын трактор 313 сум, дүүрэгт олгогдсон, 327 суманд хүлэмж баригдсан, 297 суманд зоорь баригдаж ашиглалтад оруулсан бөгөөд төслийн хэрэгжилт 93.3 хувьтай буюу нийт 3.1 тэрбум төгрөг зарцуулжээ.

3.13 Хүнсний салбарт 2005-2009 онд Улсын төсвөөс 2885,7 сая төгрөг зарцуулж, үүнээс мөнгөн зээлд 2083,1 сая төгрөг, сургалт сурталчилгаанд 314.2 сая төгрөг зарцуулсан байна.

3.14 Хүнсний салбарт хэрэгжиж буй 6 хөтөлбөрийн хүрээнд үр ашиг, үр дүн, өгөөж бий болсон талаар бодитой хэлэх зүйлгүй, хөтөлбөрүүд хангалтгүй хэрэгжиж байна

3.15 Улсын төсөв, хөрөнгө оруулалт, Тариалан эрхлэлтийг дэмжих сан, мал хамгаалах сангаас нийт 23 хөтөлбөр арга хэмжээнд 152,0 тэрбум төгрөг зарцуулсан боловч гурил, гурилан бүтээгдэхүүн, талх, нарийн боов, мах махан бүтээгдэхүүний нэгжийн үнэ буураагүй, бүтээгдэхүүний чанар сайжраагүй, үр ашиг, үр өгөөж багатай байна.

ХХААХҮ-ийн салбарт хэрэгжиж буй төсөл хөтөлбөрүүдийн хөрөнгийг арвилан хэмнэлтгүй, үр ашиггүй, зориулалт бусаар зарцуулж байна

3.16 “Сүү” хөтөлбөрийн данснаас “Сүү бэлтгэн нийлүүлэгчид, боловсруулагчдын зөвлөгөөн”-ний зардал болох 22.8 сая төгрөгийг ХХААХҮЯ-ны урсгал зардалд зарцуулсан байна.

3.17 Жижиг дунд үйлдвэрийг дэмжих хөтөлбөрийн дансаас ХХААХҮЯ-ны сургалтын төвийн байрны усны шугам угсралтын ажлын зардалд “Цэлмэг ази” ХХК-ний дансанд 15,0 сая төгрөг, сантехник угсралтын ажлын зардалд “Хөгжлийн жигүүр” ХХК-ийн дансанд 15,0 сая төгрөг буюу нийт 30,0 сая төгрөг шилжүүлж зориулалт бусаар зарцуулжээ.

3.18 “Атрын гурав дахь аян” тариалангийн үндэсний хөтөлбөрийн зардлаас медалийн үнэнд 25,6 сая төгрөг, танилцуулага орчуулж хэвлүүлэхэд 20,0 сая төгрөг, техникийн норм нормативыг тогтооход 21,3 сая төгрөг, хүнсний ногооны гар багажид 26,8 сая төгрөг, гэр худалдан авахад 10,3 сая төгрөг, ахмадын арга хэмжээнд 13,0 сая төгрөг, ажилчдын түлээ, нүүрсний хөнгөлөлтөд 6,0 сая төгрөг зориулалт бусаар зарцуулсан байна.

“Атрын гурав дахь аян”, Жижиг дунд үйлдвэрийг дэмжих, Тариалан эрхлэлтийг дэмжих сан болон хөтөлбөрөөс бий болсон 96.1 сая төгрөгийн хөрөнгийг дансанд бүртгээгүй байна

3.19 Нийслэлийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга, ХХААЯ-ны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын даргатай 2008 онд байгуулсан гэрээний дагуу 9 дүүрэгт хуваарилсан хүлэмж, бага оврын трактор зэрэг 28.2 сая төгрөгийн хөрөнгийг дүүргүүдийн ЗДТГ-т олгосон боловч хүлээн авсан иргэдтэй гэрээ байгуулаагүй, хөрөнгийг дансад бүртгэж аваагүй байв.

3.20 Төв аймгийн Жаргалант сумын ЗДТГ-т хуваарилсан хүлэмж, трактор бүхий 4.4 сая төгрөгийн хөрөнгийг тус газрын дансанд тусгаагүй байна.

3.21 Тодорхой бус зардлаас Төв аймгийн Баянчандмань сумын Эрдэнэ багийн Доргонтын эхэнд байгуулсан зуслангийн амралтын зориулалттай 5 байшин, гал зуух, саун, гүний худаг зэрэг барилгыг хөрөнгөд тусгаж аваагүй. Гэтэл сантехникийн ажил, зам талбайн ажилд хөтөлбөрөөс санхүүжилт хийж нийт 63.5 сая төгрөгийн зардал гарсан байлаа.

3.22 ХХААХҮЯ-ны Мэдээлэл, хяналт-шинжилгээ, үнэлгээний газар жил бүр хөтөлбөрүүдэд мониторинг хийж хөтөлбөрийн алдаа, дутагдлыг илрүүлж, зөвлөмж өгч байна. Сайдын зөвлөлөөр мониторингийн дүнг хэлэлцэж, гарсан зөвлөмжийг хэрэгжүүлж, хяналт тавьж ажиллахыг хөтөлбөр хариуцсан хэлтэс, газруудад үүрэг өгч байгаа боловч түүнийг хэрэгжүүлэх талаар тодорхой ажил хийгдээгүй, зөвлөмжийн биелэлтийг гаргуулж, үнэлэлт, дүгнэлт өгөөгүй байна.

Дүгнэлт:

- ХХААХҮ-ийн салбарт хэрэгжиж буй төсөл хөтөлбөрүүд дэвшүүлсэн зорилтоо бүрэн биелүүлж чадаагүй, үр дүн, үр ашиг, үр өгөөж багатай байна.
- Хөтөлбөрүүдийн хөрөнгийг арвилан хэмнэлтгүй, үр ашиггүй, зориулалт бусаар зарцуулж, бий болсон хөрөнгийг тайлан бүртгэлд дутуу бүртгэж байжээ.
- Хөтөлбөрүүдэд мониторинг хийж байгаа боловч өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Зөвлөмж:

ХХААХҮ-ийн сайд Т.Бадамжунайд:


- Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт хэрэгжиж буй хөтөлбөрт олгогдож байгаа зээлийн үйл ажиллагаанд мөрдөх журмыг баталж мөрдүүлэх,
- Хөтөлбөрийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулж байх,
- Хөтөлбөрүүдэд Мэдээлэл, хяналт шинжилгээ, үнэлгээний газраас хийсэн шалгалтын зөвлөмжийн биелэлтийг хангаж ажиллах,
- Төв аймгийн Баянчандмань сумын Эрдэнэ багийн Доргонтын эхэнд байгуулсан зуслангийн амралтын цогцолбор болон яамны сургалтын төвийн барилга байгууламжуудыг тайлан бүртгэлд бүрэн тусгах,
- Хөтөлбөрүүдийн хөрөнгийг арвилан хэмнэлтгүй, үр ашиггүй, зориулалт бусаар зарцуулсан, бий болсон хөрөнгийг тайлан бүртгэлд дутуу тусгасан холбогдох ажилтнуудад хариуцлага тооцох.

Бүлэг 4: Хөрөнгө оруулалтын үр дүн тооцогдохгүй байна

4.1 Улсын төсвийн болон МУХС-гийн тухай хуулиар ХХААХҮ-ийн салбарт санхүүжүүлэх нийт хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнд зориулан 2005 онд 702.1 сая, 2006 онд 3546.0 сая, 2007 онд 17959.1 сая, 2008 онд 45417.2 сая, 2009 онд 30905.6 сая, 2010 онд 25175.7 сая төгрөгийн төсвийг тус тус баталжээ.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын хөрөнгө оруулалт /он, сая төг/

- Улсын төсвийн хуулиар тус салбарт хийгдсэн хөрөнгө оруулалтыг 2005 онд 84.9 хувь, 2006 онд 99.4 хувь, 2007 онд 85.3 хувь, 2008 онд 99.0 хувь, 2009 онд 100 хувь санхүүжүүлжээ.
- МУХС-гийн тухай хуулиар 2007-2009 онд нийт 65.5 тэрбум төгрөг баталж, гүйцэтгэл 60.8 тэрбум төгрөг буюу 92.8 хувь байна. Үүнээс 2007 онд 1303.6 сая, 2008 онд 849.7 сая, 2009 онд 2565.2 сая төгрөгийн ажлын гүйцэтгэл дутуу байжээ.



4.2 “Улс, орон нутгийн төсөв, МУХС, гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр 2008 онд хийсэн хөрөнгө оруулалтын хэрэгжилт, үр дүн”-д хийсэн аудитаар ХХААХҮ-ийн салбарын хөрөнгө оруулалтын гүйцэтгэл хангалтгүй гэж дүгнэсний дотор ТБОНӨХБАҮХАТХ-ийг мөрдөөгүй, худалдан авах журмыг сонгож ажиллаагүй, хөрөнгө оруулалтын ажлын гүйцэтгэлд тавих үе шатны ажил хангалтгүй, зарим ажлыг хийснээр мэдээлж, санхүүжилтийг бүрэн олгосон, шаардлагатай тооцоо, судалгаа хийлгүй хөрөнгийг хавтгайруулан олгох, гүйцэтгэлийг үнэлж, хариуцлага тооцдоггүй, салбарын хэмжээнд хөрөнгө оруулалтын үр өгөөжийг тооцох, бүртгэх, тайлагнах, нэгтгэх асуудал хангалтгүй байжээ.

4.3 2008 онд ХХААХҮЯ нээлттэй тендерээр 42, хязгаарлагдмал тендерээр 2, харьцуулалтын аргаар 5, шууд гэрээгээр 2, 2009 онд нээлттэй тендерээр 39 удаа бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тендер зарласан байна.

Хөрөнгө оруулалтаар хийгдэх ажлууд хугацаандаа бүрэн хэрэгжээгүй байна

4.4 Улсын төсвийн хөрөнгөөр 2009 онд Төв аймгийн Батсүмбэр, Сэлэнгэ аймгийн Мандал, Баруунбүрэн, Сүмбэр, Хэнтий аймгийн Бор-Өндөр тосгоны нутагт услалтын системийг шинээр барих, сэргээн засварлах ажлыг гүйцэтгэсэн “Гуру”, “Зүүн хөвч”, “ISTA”, “Өгөөмөр мандал” ХХК-иудын ажлын гүйцэтгэл 20-85.0 хувьтай буюу 432.7 сая төгрөгийн ажил дутуу байхад улсын комисс хүлээн авч түүнийг үндэслэн санхүүжилтийг олгож байжээ.

4.5 Мөн ашиглалтад ороогүй хөрөнгө оруулалтын ажлыг бүрэн санхүүжүүлсэн байна. Тухайлбал, ХХААХҮЯ 2008 онд 137 зоорийг 685.5 сая төгрөгөөр, 169

хүлэмжийг 422.5 сая төгрөгөөр, 16 услалтын системийг 1127.9 сая төгрөгөөр санхүүжүүлсэн байна.

4.6 Түүнчлэн инженерийн хийцтэй худаг, уст цэг байгуулах тендерийг хугацаа алдаж зохион байгуулсан, гэрээнд заасан хугацаанд ажлыг бүрэн гүйцэтгээгүй зөрчил дутагдал Архангай, Булган, Баян-Өлгий, Баянхонгор, Дорноговь, Говь-Алтай, Хөвсгөл зэрэг аймагт гарсан байна.

4.7 Улсын төсөв, МУХС-гаас санхүүжүүлсэн ХХААХҮ-ийн салбарын 2005-2009 оны хөрөнгө оруулалтын гүйцэтгэл, 2010 оны төлөвлөгөөг үзүүлбэл: /сая.төг/

Бүтэц	Төсөл арга хэмжээ, барилга байгууламжийн нэр	2005	2006	2007	2008	2009	2005-2009 оны дүн	2010 он төл
Барилга, байгууламж	ХХААЖДҮГ-ын барилга		150.0	293.1	803.6	134.0	1380.7	
	Бизнес инкубатор, үйлдвэрлэл технологийн парк байгуулах				3 034.8		3 034.8	1 500.0
	Будаа хадгалах босоо төмөр агуулах, зоорь					3 899.4	3 899.4	
	Услалтын систем шинээр барих			1 912.2	6 821.3	3 383.7	12 117.2	6 917.1
	Газрын доорхи усны геофизикийн хайгуул явуулах			255.6		399.7	655.3	
	Инженерийн хийцтэй худаг шинээр гаргах, уст цэг байгуулах	197.2	1 554.9	9 175.1	7 912.7	3 442.8	22 282.7	4 000.0
Дүн		197.2	1 704.9	11 636.0	18 572.4	11 259.6	43 370.1	12 417.1
Их засвар	ХХААЖДҮГ-ын барилга засвар	14.5	107.0	165.8	184.9		472.2	241.6
	Услалтын систем сэргээн засварлах					1 527.5	1 527.5	
	Худаг засвар	384.1	1 642.3	1 387.2	1 487.6		4 901.2	
Дүн		398.6	1 749.3	1 553.0	1 672.5	1 527.5	6 900.9	241.6
Тон/тех	ХХААХҮЯ, ХХААЖДҮГ-ын тон/төх		72.0	128.6	197.0		397.6	202.0
	Атрын 3 дахь аян хөтөлбөрийн техник тон/төх				15 315.5	15 084.7	30 400.2	9 000.0
	Бага оврын трактор			1 472.6	6 239.0		7 711.6	
Дүн			72.0	1 601.2	21 751.5	15 084.7	38 437.4	9 202.0
Бусад	ХХААХҮС-ын төсвийн багц дахь УИХ-ын гишүүдийн хөр/оруулалт			257.3	2 406.0	471.6	3 134.9	3 315.0
Нийт		595.8	3 526.2	15 047.5	44 402.4	28 343.4	91 915.3	25 175.7

4.8 ХХААХҮ-ийн салбарт үзүүлэх улсын төсвийн дэмжлэг сүүлийн жилүүдэд өмнөх онуудаас өсч 2005-2009 онд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын нийт төсөл, арга хэмжээний санхүүжилтийн 48.9 хувийг барилга байгууламжийн, 7.8 хувийг их засварын, 43.3 хувийг техник, тоног төхөөрөмж худалдан авах зардал эзэлж байна.

Хөрөнгө оруулалтын бодлогыг шинэчлэх шаардлагатай

4.9 Төсвийн хөрөнгөөр бэлтгэгдсэн хөрөнгийн тодорхой хувийг эргэн төлүүлэхгүйгээр бусдад олгох, үр ашиггүй үрэлгэн зарцуулах явдал арилахгүй давтагдсаар байна.

Зөвхөн 2009 онд МУХС-гийн хөрөнгөөр услалтын систем шинээр барих, сэргээн засварлахад 27 ААН, 19 иргэнд 3547.2 сая төгрөгийн буцалтгүй дэмжлэг олгожээ.

4.10 2009, 2010 оны Төсвийн тухай хуулиар ХХААХҮЯ-ны өргөтгөлийн барилгын зураг төсөл болон барилга угсралтын хөрөнгө оруулалтын ажлыг санхүүжүүлэх арга хэмжээ хуульчлан батлагдаагүй атал ХХААХҮ-ийн сайдын 2009 оны 175 дугаар тушаалаар тус яамны шинээр барих өргөтгөлийн барилгын суурийн ажил гүйцэтгэх

зардлыг 1296.3 сая төгрөгөөр баталж, 2010 оны 6 дугаар сарын 1-ний гүйцэтгэлээр 986.5 сая төгрөг зарцуулсан байна.

4.11 Энэ нь ЗГТСТ хуулийн 24 зүйл, Засгийн газрын 2005 оны 139 дүгээр тогтоолоор баталсан “Тариалан эрхлэлтийг дэмжих санг бүрдүүлэх, захиран зарцуулах, түүнд хяналт тавих, тайлагнах журам”-ын 14 дүгээр зүйлийг зөрчсөн байна.

4.12 2009 онд тус салбарт хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын шинээр барилга, байгууламж барих 1581.0 сая, их засварын 272.5 сая, тоног төхөөрөмж бэлтгэх 315.3 сая, бусад арга хэмжээнд төлөвлөгдсөн 393.4 сая төгрөг тус тус зарцуулагдаагүй, төсөвт буцаан төвлөрүүлж хөрөнгө оруулалтын арга хэмжээ хэрэгжээгүй байна.

Хөрөнгө оруулалтын зарцуулалтыг санхүүжилтийн гүйцэтгэлээр тайлагнаж байна

4.13 Хуулиар батлагдсан хөрөнгө оруулалтын санхүүжилтийг хэрэгжүүлсэн арга хэмжээ бүрээр яам, аймаг, орон нутгийн ажлын комиссын хүлээн авсан актаар болон олгосон санхүүжилтийн гүйцэтгэлд үндэслэн тайлагнаж байна.

4.14 ХХААХҮЯ салбарын хэмжээнд хэрэгжүүлж буй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг нэгтгэн зохион байгуулж байгаа боловч орон нутагт хэрэгжсэн ажлын гүйцэтгэлийг хүлээн авах комиссын актыг үндэслэн санхүүжилт хийж, зарим ажлын гүйцэтгэлийг шалгах, хүлээн авах ажиллагаанд тавих хяналтыг хэрэгжүүлж чадахгүй байна. Тухайлбал,

- Услалтын системийг шинээр барих зураг төсөл шалгаруулах тендерт шалгарсан Дархан-Уул аймгийн Хонгор сумын УГТЭШХ-ийн талбайн услалтын системд 398.0 сая, “Өглөгчийн хэрэм” ХХК-д 90.0 сая, Хэнтий аймгийн Хэрлэн баян-Улаанд 194.4 сая төгрөгийг ажлын гүйцэтгэл бүрэн гараагүй байхад олгожээ.

4.15 ХХААХҮЯ хөрөнгө оруулалтын тайландаа “Шандас групп” ХХК-иас нийлүүлэх 110 тракторыг бүрэн нийлүүлснээр гаргажээ. Дээрх тракторыг худалдаж авах хөрөнгийн үлдэгдэл 3890.3 сая, мөн “Био бордооны техник тоног төхөрөөмж” худалдан авахаар хөрөнгө оруулалтаар батлагдсан 500.0 сая, бүгд 4390.3 сая төгрөгийг буудай худалдан авахад зарцуулсан байна.

4.16 2009 онд “Үр тарианы үрлүүр” нийлүүлэх тендерт шалгарсан “Онлайн датен систем” ХХК тоног төхөөрөмжөө хугацаандаа нийлүүлээгүй тул 3.6 сая төгрөгийн, “Будаа цэвэрлэгч” нийлүүлэх тендерт шалгарсан “Туул кашмер” ХХК тоног төхөөрөмжийг хугацаа алдаж нийлүүлсэнд 2.1 сая төгрөгийн алданги тооцоноос өөрөөр гэрээний үүргээ биелүүлээгүй гүйцэтгэгчид хариуцлага тооцсон гэх зүйл алга байна.

4.17 Сангийн хөрөнгөөр усалгаатай тариаланг хөгжүүлэх, услалтын систем байгуулах, сэргээн засварлах, тариалангийн газрыг нөхөн сэргээх, хөрсний үржил шимийг сайжруулах, таримал ургамлын үрийн аж ахуйг хөгжүүлэх, хөдөө аж ахуйн техник, технологийн шинэчлэл хийх, тариалангийн үйлдвэрлэл эрхлэгчээс стандартын шаардлага хангасан буудай худалдан авах, тусгай сангийн үндсэн хөрөнгөд засвар үйлчилгээ хийх зэрэг арга хэмжээг санхүүжүүлж байхаар хуулиар¹⁶

¹⁶ Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 24 дүгээр зүйл. Тариаланг дэмжих сан

зохицуулсан байдаг ч ХХААХҮ-ийн салбарын хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгаагүй арга хэмжээг ТЭДС-гаас санхүүжүүлж байна.

4.18 ХХААХҮ-ийн салбарт хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хүрээнд хэрэгжүүлсэн худалдан авах ажиллагааны хэрэгжилтийн үнэлгээг авч үзвэл:¹⁷

2008 он	2009 он
Тайландаа мэдээллийг бүрэн тусгаагүй, тендер шалгаруулалтын аргыг сонгохдоо хууль зөрчсөн, гэрээ байгуулах зөвшөөрөлгүй бүгд 7.0 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий ажлын тендерийн санхүүжилтийг гаргасан, тендер шалгаруулалтын урилга, үр дүнг нийтлээгүй, тендер шалгаруулалттай холбоотой нийт 7 гомдол гарч хянан шийдвэрлэсэн бөгөөд эдгээрээс 3-т нь тендэрт оролцогчдын гаргасан гомдол үндэслэлтэй нь тогтоогдож байжээ.	Хуулийн дагуу тендер шалгаруулалтыг зохион байгуулсан ч тендерийн үр дүнг нийтлээгүй, тендер шалгаруулалт, үнэлгээтэй холбогдсон гомдол арилаагүй, шалгаруулалт хүчингүй болж дараа онд шилжих, зарим төслийг алдаатай боловсруулсан байжээ.

Хөрөнгө оруулалтын ажлыг тайлан тэнцэлд тусгах, бүртгэх талаар хангалтгүй ажиллаж байна

4.19 “Агропарк” төслийн хүрээнд олгогдсон тракторыг данс бүртгэлд тусгах асуудал хангалтгүй байна. Тухайлбал,

- Увс аймагт 6, Баянхонгор аймагт 10, Дорноговь аймагт 5, Булган аймагт 12, Хэнтий аймагт 16 тракторыг сумын ЗДТГ-ын данс бүртгэлд тусгаагүй.
- Хэнтий аймагт 123.7 сая төгрөгийн 13 худаг, 236.3 сая төгрөгийн зоорь, хүлэмж, Дундговь аймагт 360.0 сая төгрөгийн 30 худгийг данс бүртгэлд тусгаагүй.

¹⁷ Эх үүсвэр: Сангийн яам, Худалдан авах ажиллагааны бодлогын газар

Дүгнэлт:

- Төслийн хүрээнд хэрэгжиж буй хөрөнгө оруулалтын гүйцэтгэлд хяналт тавиагүй, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ бүрэн хийгдэхгүй байгаагаас төслийн хөрөнгө үр ашиггүй зарцуулагдаж байна.
- Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг мөрдөөгүй, худалдан авалтын журмыг зөв сонгож ажиллаагүй байна.
- Хөрөнгө оруулалтаар хийсэн ажил, үйлчилгээний гүйцэтгэлд тавих хяналт хангалтгүй, зарим ажлыг хийснээр мэдээлж, санхүүжилтийг олгож байжээ.
- Хөрөнгө оруулалтаар санхүүжигдсэн худаг, зоорь, хүлэмж, хөдөө аж ахуйн техник, тоног төхөөрөмжийг данс бүртгэлд тусгахгүй, гэрээний гүйцэтгэлийг үнэлж хариуцлага тооцохгүй байна.
- Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнд өмнө нь хийсэн аудитын дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр зохион байгуулж буй ажлын үр дүн хангалтгүйгээс зөрчил, дутагдал давтагдаж байна.

Зөвлөмж:

ХХААХҮ-ийн сайд Т.Бадамжунайд:

- ХХААХҮ-ийн салбарын хөрөнгө оруулалтаар хийгдэх ажлын явц, түүний чанарт тавих хяналтыг чангатгах, ажлыг хугацаанд нь хийж гүйцэтгүүлж байх,
- Хөрөнгө оруулалтын санхүүжилтийг ажлын үе шат бүрээр гүйцэтгэлийг тооцож олгож байх,
- Өмнөх онуудад Үндэсний аудитын газраас тус салбарын хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа, хэрэгжилтэд хийсэн аудитын дүгнэлт, зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлэх.
- Хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгийг бүртгэл тайланд бүрэн тусгах, энэ ажлыг хийж гүйцэтгэхэд хариуцлагагүй хандсан холбогдох албан тушаалтанд хариуцлага тооцох.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас ирүүлсэн санал:



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОР
Ч.РАДНАА ТАНАА

**МОНГОЛ УЛСЫН
ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ,
ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН
САЙД**

13381 Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг,
Энхтайваны өргөн чөлөө 16а, Засгийн газрын IX байр,
Утас: 26-22-71, Факс: (976-11) 45-25-54,
E-mail: mofa@mofa.gov.mn; http://www.mofa.gov.mn

2010-7-05 № 1/АА59
танай _____-ны № 551 -Т

551 тоот албан бичгийн хариу

Улсын төсвөөс санхүүжүүлсэн хөдөө аж ахуйн чиглэлийн хөрөнгө оруулалт, сан, төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн гүйцэтгэлийн тайлантай танилцлаа.

Танайхаас өгсөн зөвлөмжийг хүлээн зөвшөөрч байгаа боловч доорх саналыг тусгаж өгөхийг хүсч байна. Үүнд:

Тайлбар 1-ийг үзнэ үү.

1.4-т:

Тариалан эрхлэлтийг дэмжих сан нь улсын төсвийн санхүүжилтгүйгээр аж ахуйн дотоод тооцоон дээр ажиллаж, өөрөө өөрийгөө санхүүжүүлэн үйл ажиллагаа явуулдаг учраас бусад тусгай сангуудаас онцлогтой тул жил бүр батлагдсан Төсвийн тухай хуулийн хүрээнд үйл ажиллагаа явуулах боломжгүй.

Тайлбар 2-ыг үзнэ үү.

1.16-д:

2008 оны төвлөрсөн арга хэмжээний зардлын төсөв 9605.8 сая төгрөгөөр батлагдсанаар тухайн жил 10195.6 сая төгрөгийн зардал гарч уг зардал 589.8 сая төгрөгөөр хэтэрсэн нь “Атрын гурав дахь аян”-ы үндэсний хөтөлбөр батлагдсанаар Сангийн яамны хүрээнд нэлээдгүй зардал гарсантай холбоотой.

Ажиллагсад олгож байгаа урамшуулал нь Сангийн дотоод журамд заасны дагуу жил бүрийн төрийн өмнөөс гүйцэтгэсэн ажил үйлчилгээний зардалд тусгагдан төсөвлөгдсөн байдаг.

Тайлбар 3-ыг үзнэ үү.

1.17-д:

Гэрэл цахилгаан, тээвэр, шуудан холбоо, дотоод томилолт, урсгал засвар, төлбөр хураамж болон цалин шимтгэлийн зардал хэтэрсэн нь 2008 оны ургацаас дотоодын зах зээл дээрээс төсөвлөснөөс их хэмжээний улаан буудайг тус санд байршуулсантай холбогдон улаан буудайг хадгалах цэвэрлэх, сэлгэх зэрэг үйл ажиллагаанаас шалтгаалан цаг үеийн компаниг ажилд шаардлагатай гэрээт ажилчдын цалин болон гэрэл цахилгаан, халаалт зэрэг ашиглалтын зардлууд өссөнтэй холбоотой.

2009 онд 5215.0 сая төгрөг төлөвлөгдөөгүй зардал гарсан гэжээ.

Ажиллагсад олгосон урамшуулал нь Төрийн өмнөөс гүйцэтгэх ажил үйлчилгээний зардалд төсөвлөгдсөн. 4697.1 сая төгрөг нь Сангийн яам болон Монгол Банкны хүсэлтээр “Гацуурт” ХХК-д олгогдох буудайн үнэ он дамжиж олгогдсон нь Төсвийн гүйцэтгэлийн тайлангаар тухайн ондоо хэмнэгдэж, дараа ондоо хэтэрсэн мэт харагдаж байна. Харин ОХУ-ын зээлтэй холбогдон гарсан 454.2 сая төгрөг нь төсөвлөгдөөгүй боловч Төрийн өмнөөс гүйцэтгэх ажил үйлчилгээний зардлаар тусган тайлбарлах нь зүйтэй болов уу.

0800735

Тайлбар 4-ийг үзнэ үү.

1.20-д:
Өөрийн хөрөнгийн эх үүсвэрээр хөрөнгө оруулалтад 500.0 сая төгрөг төлөвлөснөөс өргөтгөлийн барилгын санхүүжилтэд 2009 онд 317.5 сая төгрөг зарцуулсан байна.

Тайлбар 5-ыг үзнэ үү.

1.25-д:
Улаан буудайн урамшуулалд олгогдоогүй 860.3 сая төгрөгийг 2010 оны улаан буудайн урамшуулалд нөхөн олгохоор тусгах.

Тайлбар 6-г үзнэ үү.

1.29-д:
Монгол Улсын Засгийн газрын 2005 оны 139 дүгээр тогтоолоор батлагдсан “Тариалан эрхлэлтийг дэмжих санг бүрдүүлэх, захиран зарцуулах, түүнд хяналт тавих, тайлагнах журам”-ын 2 дугаар бүлгийн 8.4 дэх заалтыг үндэслэн Гүйцэтгэх захирлын үйл ажиллагааны үр дүнг хэлэлцэн шагнал урамшууллын асуудлыг шийдвэрлэж байх эрхийг Сангийн удирдах зөвлөлд олгосноос гадна, Сан нь аж ахуйн дотоод тооцоон дээр үйл ажиллагаа явуулдаг учир ашгийн төлөө бус хуулийн этгээд гэж шууд дүгнэж болохгүй.

Тайлбар 7-г үзнэ үү.

1.32-т:
Газар тариалангийн үйлдвэрлэл нь эрсдэлтэй учраас зарим тохиолдолд улаан буудайн мөндөр хяруунд цохиулах, ургамлын харуу өвчин гарах зэрэг ургац алдах магадлал өндөр байдаг. Дээрх шалтгааны улмаас ОХУ-ын зээлийн техник авсан аж ахуйн нэгжээс 157.2 сая төгрөгийг эргэн төвлөрүүлж чадаагүй.

Тайлбар 8-ыг үзнэ үү.

1.35-д:
Авч хэрэгжүүлсэн арга хэмжээний хүрээнд 2009 онд аж ахуйн нэгж, иргэдээс авах авлагын хэмжээ 31.8 тэрбум төгрөгөөр нэмэгдэж нийт авлагын хэмжээ 38.9 тэрбум төгрөгт хүрсэн байна.

Хүнсний улаан буудайн зах зээл дээрх борлуулалт муу болон буудай хадгалах агуулах савны багтаамж байхгүйгээс буудайг 10 гурилын үйлдвэрт зээлээр олгосноос 7.9 тэрбум төгрөгийн авлага нэмэгдсэн. Энэхүү төлбөрүүд нь 2010 оны 1 дүгээр улиралд багтаан төлөгдөхөөр гэрээг сунгаснаас хугацаа хэтэрсэн авлагыг нэмэгдүүлсэн байна. Энэ авлагаас 2010 оны 06 дугаар сарын 30-ны байдлаар 7360.5 сая төгрөг барагдаж, 574.2 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Дээрх улаан буудайн борлуулалтаас үүссэн авлага барагдсанаар өнөөдрийн байдлаар нийт авлагын 33 хувь буюу 13016.9 сая төгрөг хугацаа хэтэрсэн байна.

Хугацаа хэтэрсэн авлага үүсэх гол шалтгаан нь 2009 онд “Атрын гурав дахь аян”-ы хүрээнд маш их хэмжээний дэмжлэг олгогдсон мөн шинээр тариалангийн үйлдвэрлэл эхлэн явуулж байгаа аж ахуйн нэгж, иргэдийн тоо эрс нэмэгдэн уриншийн зээл, техник ихээр авснаар дараа тухайн ондоо борлуулалтгүйгээс зээлээ эргэн төлж чадахгүй байдал гарч байна.

Тайлбар 9-ийг үзнэ үү.

1.39-т:
Шатахуун зээлээр олгосон аж ахуйн нэгжүүдээс төлбөрт буудай тооцож авсан бөгөөд улаан буудай борлогдсоны дараа гэрээт газруудад шатахууны үнийг бүрэн барагдуулах юм.

Тайлбар 10-ыг үзнэ үү.

1.46-д:
Тус салбарын тухайн жилийн санхүүгийн тайлан тэнцэлд тусгасан буудайн орлого зарлагын тооцоо тохиорч байгаа бөгөөд харин стандартын шаардлага хангаагүй хорогдолд тооцсон тэжээлийн буудайнаас иргэн С.Эрдэнийн нэр дээр ... гэж нэмж оруулах.

Бусад заалт нь Сангийн буудайн тооцоонд хамрагдахгүй тул хасах.

Тайлбар 11-ийг үзнэ үү.

1.47-д:
Сангийн 2006 оны санхүүгийн тайлан тэнцэлд тусгасан заалтыг нэмж оруулах.

Тайлбар 12-ыг үзнэ үү.

1.48-д:
Хөтөл салбарт 572.6 тонн, Сэлэнгэ, “Алтан тариа”, “Гацуурт” ХХК-д 284.6 тонн буудай дутахаар байна гэсэн хэсгийг санхүүгийн баримтаар нотлогдоогүй тул хасах саналтай байна.

“Агропарк”-ийн талаар:

“Агропарк” төслийн санхүүжилтэд төсвийн дагуу зарцуулагдах нийт 3075.4 сая төгрөгийн санхүүжилтийг бүрэн олгож, уг үйл ажиллагааны хөрөнгө оруулалтын зардал бүрэн тусгагдсан болно. Данс бүртгэлд тусгах, ашиглалтад хяналт тавих үүргийг аймгуудын Хүнс, хөдөө аж ахуй, жижиг, дунд үйлдвэрийн газар, сумын Засаг даргын Тамгын газар хариуцна.

Тайлбар 13-ыг үзнэ үү.

4.3-т:
Услалтын системийн барилгын ажлыг 2009 онд ашиглалтад хүлээн авах ажлыг тухайн аймгийн Мэргэжлийн хяналтын газрын даргын тушаалаар байгуулагдсан Улсын комисс хариуцан зохион байгуулсан болно. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам нь услалтын системийн барилгын ажлыг ашиглалтад хүлээн авсан Улсын комиссын акт, ажлыг бүрэн хийж дуусгасан тухай төсөл хэрэгжүүлэгч, барилгын ажлын гүйцэтгэгч нарын ирүүлсэн барилгын болон санхүүжилтийн гүйцэтгэлийн тайланд үндэслэн хөрөнгө оруулалтыг олгосон.

Дүгнэлт хэсгийн талаар:

Дүгнэлт хэсгийн 3 дахь хэсэг дэх 20.9 тэрбум төгрөгийн хугацаа хэтэрсэн өрийг эргэн нягтлах;

5 дахь хэсэгт, гадаад, дотоод байгууллага гэснийг хасах;

7 дахь хэсэгт Тариалан эрхлэлтийг дэмжих сан ашгийн төлөө бус байгууллага гэдгийг хасч 357.1 сая төгрөгийн урамшууллыг олгох эрх зүйн үндэс нь байгаа тул Төсвийн ерөнхийлөн захирагч, Удирдах зөвлөлийн гишүүдэд хавтгайруулан олгосон байна гэж засч найруулах;

**Тайлбар 14-ийг үзнэ үү.
Тайлбар 15-ыг үзнэ үү.
Тайлбар 16-г үзнэ үү.**

10 дахь хэсэгт Тариалан эрхлэлтийг дэмжих сангийн салбаруудын үйл ажиллагаанд “тариаланчдаас авсан буудайд чийг, хогт хольцын хорогдолд тооцож, цэвэрлэгээнээс гарсан хаягдал тэжээлийн” буудайг ... гэж нэмж оруулан найруулах;

Тайлбар 17-г үзнэ үү.

11 дэх хэсэгт: Баримтаар нотлогдоогүй тул хасах.

Тайлбар 18-ыг үзнэ үү.

САЙД  Т.БАДАМЖУНАЙ



Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны саналд өгөх тайлбар:**Тайлбар 1**

Тайлангийн энэ хэсэгт тус сангийн үйл ажиллагааг зохицуулсан журмын мөрдөлт хангалтгүй байгааг дурьдсан тул тайланд өөрчлөлт оруулах шаардлагагүй гэж үзлээ.

Тайлбар 2

Саналыг хүлээн авч зарим тоон үзүүлэлтийг өөрчлөв.

Тайлбар 3

Саналыг хүлээн авч зарим тоон үзүүлэлтийг өөрчлөв.

Тайлбар 6, 7, 9, 11, 13

Тайлангийн төсөлд дурдсан аудитын зарим илрүүлэлт, үр дүнгийн тоон мэдээлэлд тайлбар хийсэн агуулгатай байгаа учраас тайланд ямар нэг өөрчлөлт хийх шаардлагагүй гэж үзэв.

Тайлбар 4

“... 2009 онд 317.5 сая төгрөг, 2010 оны 5 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 669.0 сая төгрөг, нийт 986.5 сая төгрөг зарцуулсан байна” гэж өөрчлөв.

Тайлбар 5

2009 оны ургацын буудайн урамшууллын зарцуулагдаагүй үлдэгдэл 860.3 сая төгрөгийг 2009 онд худалдан авсан буудайн төлбөрт зарцуулжээ” гэж өөрчлөлт хийв. Энэхүү асуудлаар УАГ-ын албан шаардлага өгсөн болно.

Тайлбар 8

Бид ТЭДС-гийн 2009 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан тэнцлээр илэрхийлэгдсэн нийт авлагын дүн, үүнээс тооцоо нийлээгүй авлагын талаар тайлагнасан учраас өөрчлөлт хийх шаардлагагүй юм.

Тайлбар 10

Цуглуулсан нотлох баримтаар батлагдаж байгаа тул саналыг хүлээн авах боломжгүй гэж үзэв.

Тайлбар 12

Хэмжилтийг практик аргаар тооцон үзэхэд хадгалагдаж буй буудайн үлдэгдэл байвал зохих хэмжээнээс дутаж болзошгүй гэж үзсэн болно.

“Агропарк төсөл”-ийн 2008 оны санхүүжилтэд 3.8 тэрбум төгрөг төсөвлөн, 3.1 тэрбум төгрөгийн гүйцэтгэлтэй гарсныг тайлангийн 3.12 дахь хэсэгт тодруулж өгөв.

Тайлбар 14

“... авлагын 53.7 хувь нь хугацаа хэтэрсэн байна” гэж өөрчлөв.

Тайлбар 15

Саналыг хүлээн авч өөрчлөлт хийв.

Тайлбар 16

“ТЭДС 357.1 сая төгрөгийн урамшууллыг Төсвийн ерөнхийлөн захирагч, удирдах зөвлөлийн гишүүд, Сангийн удирдлага болон ажилтнуудад хавтгайруулан олгож төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан байна” гэж өөрчлөлт хийв.

Тайлбар 17

“ТЭДС-гийн салбаруудын үйл ажиллагаанд “хүнсний болон тэжээлийн” буудай гэж нэмж оруулав.

Тайлбар 18

“ТЭДС-гийн салбаруудын селос агуулахад хадгалагдаж байгаа буудайг хэмжих, жигнэх боломжгүйгээс нягтлан бодох бүртгэлээр байвал зохих үлдэгдэлтэй тохирч байгаа эсэхийг баталгаажуулж чадахгүй байна” гэж өөрчлөв.


ТАРИАЛАН ЭРХЛЭЛТ, ГОЛ НЭРИЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ НИЙЛҮҮЛЭЛТИЙН СУДАЛГАА-1

Үзүүлэлт	2004 он	2005 он	2006 он	2007 он	2008 он	2009 он
Зарим бүтээгдэхүүний жилийн дундаж үнэ, Үүнээс:						
<i>Аймгуудыг бүсчилснээр /гурил, кг/</i>						
1 Баруун бүс	441,4	399,4	447,4	547,2	866,2	768,6
2 Хангайн бүс	441,7	442,2	434,0	513,8	851,5	752,2
3 Төвийн бүс	470,3	461,3	455,0	534,6	856,6	757,9
4 Зүүн бүс	474,0	486,7	431,7	507,3	881,3	766,3
Нийслэлд						
5 Гурил, 1-р зэрэг /кг/	455,0	417,0	405,0	493,0	783,0	726,0
6 Талх, "Атар"	298,0	318,0	320,0	360,0	592,0	612,0
ХАА-н үйлдвэрлэл, Үүнээс:						
<i>Гол нэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл</i>						
7 Улаан буудай /мян.т/	135,6	73,5	127,8	109,6	209,8	388,1*
8 Гурил /мян.т/	57,8	58,3	63,6	70,8	62,0	105,3
ХАА-н үйлдвэрлэл						
9 Тариалсан талбай /мян.га/	172,9	159,1	126,2	121,8	154,0	252,4
10 Нэг га талбайн ургац /цн/	8,1	4,8	10,8	9,4	14,0	15,6
Импортын гол нэрийн бараа, Үүнээс:						
11 Үр тариа /мян.т/	114,9	97,5	102,2	92,8	171,3	114,7
12 Гурил /мян.т/	79,3	103,9	105,6	112,3	132,9	105,7
Гурилын нийлүүлэлт						
13 Гурилын хэмжээ /8+23/	137,1	162,2	169,2	183,1	194,9	211,0
14 Үүнээс, импортын эзлэх %	57,8	64,1	62,4	61,3	68,2	50,1

Тэмдэглэл: *Урьдчилсан гүйцэтгэлээр,
Эх үүсвэр: Монгол улсын статистикийн эмхтгэл 2007, 2009 он

Дотоодод борлуулж буй гурилын дундаж үнэ*

Үнийн мэдээлэл*



Тэмдэглэл: *Тариалан эрхлэлтийг дэмжих сан

Барааны нэр	2010 он		
	VI/09	VI/16	
"Алтан тариа" гурил /кг/	дээд	643	645
	I зэрэг	578	529
	II зэрэг	433	433
"Алтан тариа" савласан гурил /кг/	дээдийн дээд	971	971
	дээд	684	984
	I зэрэг	587	587
	II зэрэг	492	492
Гурил, /кг/ дээд, Орос	642	642	
Гурил, /кг/ I зэрэг, Орос	540	540	
Гурил, /кг/ Дээд, Хятад	803	803	
Талх, "Атар" /ш/	629	629	

Тэмдэглэл: *www.mofa.gov.mn

Статистик мэдээллийн үр дүн:

- Хүнсний буудайн үйлдвэрлэл 2009 онд 388.1 мянган тонн байгаа нь 2006 оноос 3 дахин, 2007 оноос 3.5 дахин, 2008 оноос 1.8 дахин нэмэгджээ.
- Дотоодын гурилын үйлдвэрлэл 2009 онд 105.3 мянган тонн буюу 2006 онтой харьцуулахад 1.6 дахин, 2007 оноос 1.5 дахин 2008 оноос 1.7 дахин тус тус нэмэгджээ.
- Импортын гурилын хэмжээ 2009 онд 105.7 мянган тонн буюу 2007 онтой харьцуулахад 5.9 хувиар, 2008 оноос 20.5 хувиар буурсан бөгөөд, харин хүнсний буудайн импортын хэмжээ 2009 онд 2008 оныхоос 33.0 хувиар буурсан байна.
- Гурилын үнэ жилийн дундаж нийслэлд 2009 онд 2008 оныхоос 7.3 хувиар буурсан байна.
- 2009 онд 114.7 мянган тонн буудай импортлосон нь 2006 оноос 12.2 хувиар, 2007 оноос 23.6 хувиар тус тус өсчээ.
- Гол нэрийн бүтээгдэхүүнээр авсан гурилын жилийн дундаж үнэ 2009 онд нийслэлд 726 төгрөг байгаа нь 2006 оныхоос 79.2 хувиар, 2007 онд 47.2 хувиар өссөн байна.
- Мөн жишээ болгон авсан "Атар" талхны үнэ 2009, 2010 онд буураагүй байна.

ХХААХҮ-ийн салбарт 2005-2009 онд хэрэгжиж буй дотоодын хөтөлбөрийн судалгаа

/сая төгрөгөөр/

№	Хэрэгжиж буй хөтөлбөр, төсөл	Өийдвэрийн он, дугаар	Хэрэгжих хугацаа	Төсөвт өртөг	Төлөвлөлт	Зарцуулалт	Зөрүү (+,-)	Тайлбар
1	Эрчимжсэн мал аж ахуйн хөгжлийг дэмжих хөтөлбөр	ЗГ-ын 2003 оны 160 дугаар тогтоол	2003-2015		3,741.9	4,514.4	772.5	Хөтөлбөрийн зээлийн гэрээг МЭҮГ-т хийж, төсөл сонгон шалгаруулалтыг ХХААХҮЯ-ны МАААБХЗГ зохион байгуулжээ
2	Цаа бугын аж ахуйг сэргээх, цаачдын амьдралын түвшинг сайжруулах хөтөлбөр	ЗГ-ын 2007 оны 255 дугаар тогтоол	2007-2015	511.0	148.0	151.1	3.1	Хөтөлбөрийн хамрах хүрээ бага тул дэвшүүлсэн зорилтууд биелж байна
3	Малын тэжээл хөтөлбөр	СГ-ын 2007 II ү 283 абааааd оiаdiiё	2008-2015	69,057.6	1,351.6	1,482.1	130.5	Орон нутагт хөтөлбөрийг хэрэгжүүлсэн тайлан мэдээ дутуу байна. 2009 онд мониторингийн шалгалтанд ороогүй байна
4	Малын чанар сайжруулах хөтөлбөр	ЗГ-ын 2006 оны 93 дугаар тогтоол	2006-2015	8,806.5	941.4	941.4		Аудитын явцад хөтөлбөрийн судалгаа гаргаж өгсөн боловч хариуцсан мэргэжилтэн тодорхойгүй байлаа
5	Малын эрүүл мэнд хөтөлбөр	ЗГ-ын 1999 оны 64-р тогтоол	1999-2010		26,411.5	30,533.9	4,122.4	Судалгаа гаргаж өгсөн боловч, хариуцсан мэргэжилтнүүд анхан шатны баримт материалыг танилцуулсангүй
6	Үхэр, хонь, ямааны бруцеллөз өвчинтэй тэмцэх төсөл	ЗГ-ын 2001 оны 206-р тогтоол	2002-2009	11,125.0	3,435.3	3,427.6	(7.7)	
7	Хүнсний баталгаат байдал хөтөлбөр	Засгийн газрын 2009 оны 32 дугаар тогтоол	2009-2016			13.0		Төсөв хийгдээгүй. 2009 онд хөрөнгө төсөвлөөгүй, өмнөх "Хүнсний хангамж, аюулгүй байдал, хоол тэжээл" хөтөлбөрт ХХААХҮС-ын 2009 оны 81 тушаалаар 13.0 сая төгрөгийг баталжээ. Баримт материалыг танилцуулаагүй
8	Хүнсний хангамж, аюулгүй байдал, хоол тэжээл хөтөлбөр	Засгийн газрын 2001 оны 242-р тогтоол	2001-2010	64,399.9	123.1	125.5	2.4	Уг хөтөлбөр нь ЗГ-ын "Хөтөлбөр батлах тухай" 2009 оны 32 дугаар тогтоолоор хүчингүй болсон. Хариуцсан мэргэжилтэн баримт материал танилцуулаагүй.
9	Сүү хөтөлбөр	ЗГ-ын 2006 оны 239-р тогтоол	2007-2016		1,419.3	1,419.3		Хөтөлбөр хариуцсан мэргэжилтэн олон удаа солигдсон, хяналт тавих ажил муу явагдсан
10	Экологийн цэвэр бүтээгдэхүүн	ЗГ-ын 2006 оны 50 дугаар тогтоол	2006-2015		136.7	136.7		Судалгаа гаргаж өгсөн боловч анхан шатны баримт материалыг танилцуулсангүй
11	Иод дутлын эмгэгтэй тэмцэх хөтөлбөр	ЗГ-ын 2007 оны 85 тогтоол	2007-2010		102.6	102.6		Аудитад хамрагдсан болно
12	Ногоон хувьсгал үндэсний хөтөлбөр	ЗГ-ын 2004 оны 169-р тогтоол	2005-2012	4,910.0	1,339.9	1,340.2	0.3	Аудитад хамрагдсан болно
13	"Атарын гурав дахь аян" тариалангийн хөгжлийн үндэсний хөтөлбөр "Агропарк" төсөл	ЗГ-ын 2008 оны 70-р тогтоол	2008-2010	78,795.7	74,723.7	71,626.0	(3,097.7)	Аудитад хамрагдсан болно
14	Хоршоог хөгжүүлэх нийгмийн хэмжээний хөтөлбөр	ЗГ-ын 2003 оны 220, 2009 оны 173	2004-2013	2,277.0	1,474.6	163.7	(1,310.9)	2004-2008 онд нийт 198.7 сая төгрөг зарцуулсан, 2009 онд төлөвлөсөн зардлыг зарцуулж чадаагүй байна.
15	Ой мод боловсруулах үйлдвэрлэлийг сэргээх, тухайн чиглэлээр байгуулагдсан тосгоны хүн амын хөдөлмөр эрхлэлт, нийгмийн асуудлыг шийдвэрлэх арга хэмжээний хөтөлбөр	УИХ-ын 2000 оны өдрийн 30 дугаар тогтоол	2000-2010	540.0	17.1	17.1		Аудитад хамрагдсан болно
16	Хэвлэлийн үйлдвэрлэл хөтөлбөр	ЗГ-ын 2008 оны 53 дугаар тогтоол	2008-2016	35,770.0	21.6	18.4	(3.2)	Аудитад хамрагдсан болно
17	Жижиг дунд үйлдвэрийг дэмжих хөтөлбөр	ЗГ-ын 2005 оны 64, 2009 оны 280-р тогтоол	2005 - 2010	19,410.0	61,359.7	35,195.8	(26,163.9)	2010 онд гүйцэтгэлийн аудитад хамрагдсан болно
18	Оёмол бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг хөгжүүлэх хөтөлбөр	ЗГ-ын 2003 оны 207-р тогтоол	2003-2015 он	39.0	27.5	27.5		Аудитад хамрагдсан болно
19	Ахуйн үйлчилгээний салбарыг дэмжих хөтөлбөр	ЗГ 2008.07.09-ны өдрийн 288 дугаар тогтоол	2008-2016					Аудитад хамрагдсан болно
20	Арьс шир хөтөлбөр	ЗГ-ын 2001 оны 114	2001-2010		52.9	52.9		Аудитад хамрагдсан болно
21	Ноос дэд хөтөлбөр	ЗГ-ын 2001 оны 26 дугаар тогтоол	2001-2010	10,834.7	5.1	5.1		Аудитад хамрагдсан болно
22	"Бөөний худалдааны сүлжээ"	ЗГ-ын 2001 оны 219, 2005 оны 249, 2008 оны 169	2001-2012	6,460.0	1,690.0	1,110.0	(580.0)	Улсын төсвөөс 4460.0 сая төгрөг төлөвлөсөн ч 1500.0 сая төгрөг олгож, олгосон зээлийн эргэн төлөлтөөс аймгуудад олгох замаар 3360.0 сая төгрөг зарцуулсан байна.
Нийт дүн					312,936.4	178,523.5	152,404.3	(26,132.2)



**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОРЫН ТУШААЛ**

2010 оны 07 сарын 08 өдөр

Дугаар 69

Улаанбаатар хот

Аудитын тайланг баталгаажуулах тухай

“Төрийн аудитын тухай хууль”-ийн 13.4.5, “Гүйцэтгэлийн шалгалтын журам”-ын 23.2, “Гүйцэтгэлийн аудитын тайланг хянан баталгаажуулах журам”-ын 4.2-т заасныг үндэслэн ТУШААХ нь:

Нэг.Улсын төсвөөс санхүүжүүлсэн хөдөө аж ахуйн чиглэлийн хөрөнгө оруулалт, сан, төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтэд хийсэн аудитын тайланг баталсугай.

Хоёр.Аудитаар илэрсэн төлбөр, зөрчлийн жагсаалтыг 1 дүгээр хавсралтаар баталсугай.

Гурав.Аудитын тайланг Улсын Их Хурлын Аюулгүй байдал, гадаад бодлогын Байнгын хороо, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Тариалан эрхлэлтийг дэмжих сан, Мал эмнэлэг, үржлийн газарт хүргүүлсүгэй.

Дөрөв.Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, үр дүнг 2010 оны 12 дугаар сарын 1-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Т.Бадамжунайд зөвлөсүгэй.

Тав.Аудитын тайланд тусгагдсан зөрчлийн барагдуулалт, зөвлөмж, төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцон Удирдлагын зөвлөлд танилцуулахыг Гүйцэтгэлийн аудитын газрын захирал Д.Ганбилэгт үүрэг болгосугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР



Ч.РАДНАА

07-052

Монгол Улсын Ерөнхий аудиторын
2010 оны 7 дугаар сарын 8-ний 69 дугаар
тушаалын 1 дүгээр хавсралт

Улсын төсвөөс санхүүжүүлсэн хөдөө аж ахуйн чиглэлийн хөрөнгө оруулалт, сан, төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтэд хийсэн гүйцэтгэлийн аудитаар илрүүлсэн төлбөр, зөрчлийн жагсаалт

(сая төгрөгөөр)

Д/д	Төлбөр хариуцагчийн		Төлбөр зөрчлийн товч агуулга	Төлбөрийн дүн	Зөрчлийн дүн
	Нэр	Албан тушаал			
1	Л.Дүйнхэржав Г.Амгалан	ТЭДС-гийн гүйцэтгэх захирал ТЭДС-гийн ерөнхий нягтлан бодогч	ХХОАТ-ыг төсөвт төвлөрүүлэх	12.7	
2	М.Шинэчулуун	"Сэлэнгэ буудай" ХХК-ийн захирал	ТЭДС-гийн Сэлэнгэ салбараас ачуулсан буудайны үнэ төлүүлэх	125.0	
3	Ч.Атарсайхан	"Энхбүрэн өндөр" ХХК-ийн захирал	Урамшууллыг төлүүлж төсвийн орлого болгох	24.2	
4	Д.Энхбаяр	"Оргилдэлгэр" ХХК-ийн захирал	Урамшууллыг төлүүлж төсвийн орлого болгох	19.8	
5	М.Сэвжидмаа	"Булган хануй" ХХК-ийн захирал	Урамшууллыг төлүүлж төсвийн орлого болгох	15.2	
6	Л.Дүйнхэржав Г.Амгалан	ТЭДС-гийн гүйцэтгэх захирал ТЭДС-гийн ерөнхий нягтлан бодогч	Улсын төсвөөс олгосон буудайн урамшууллыг зориулалтын дагуу зарцуулах		860.3
7	Л.Дүйнхэржав Г.Амгалан	ТЭДС-гийн гүйцэтгэх захирал ТЭДС-гийн ерөнхий нягтлан бодогч	Хугацаа хэтэрсэн зээлийн өрийг төлүүлэх		3,175.2
8	Л.Дүйнхэржав Г.Амгалан	ТЭДС-гийн гүйцэтгэх захирал ТЭДС-гийн ерөнхий нягтлан бодогч	ХХААХҮЯ-ны өргөтгөлийн барилгыг санхүүжүүлсэн		986.6
9	П.Дамдиндорж Н.Бат-Оюун	Мал эмнэлэг, үржлийн газрын дарга Мал эмнэлэг, үржлийн газрын ерөнхий нягтлан бодогч	Зориулалт бусаар зарцуулсан хөрөнгийг төлүүлэх	7.9	
10	Т.Бадамжунай Л.Дүйнхэржав	ХХААХҮ-ийн сайд ТЭДС-гийн гүйцэтгэх захирал	Хугацаа хэтэрсэн зээлийн өрийг төлүүлэх		28.0
11	Ц.Энхбат Д.Чулуунбат М.Дашдулам Н.Хорлоо	Төв аймгийн Засаг дарга ЗДТГ-ын ҮДББОБЗХ-ийн дарга ХХААГ-ын мэргэжилтэн Сан хариуцсан нягтлан бодогч	Барьцаа хөрөнгийн баталгаагүйгээр олгосон зээлийг төлүүлэх		50.0
12	П.Дамдиндорж Р.Цогтбаатар	Мал эмнэлэг, үржлийн газрын дарга Мал эмнэлэг, үржлийн газрын албаны дарга	Барьцаа хөрөнгийн баталгаагүйгээр олгосон зээлийг төлүүлэх		100.0

13	Д.Цолмон Б.Цогтсаран	Аймаг дундын отрын бэлчээр ашиглалтын захиргааны дарга ТЭДС-гийн Хангамж борлуулалтын албаны дарга	"Сэлэнгэ төгөлдөр" ХХК-ийн нэр дээр авсан зээлийг төлүүлэх	48.0	
14	П.Дамдиндорж Н.Бат-Оюун	Мал эмнэлэг, үржлийн газрын дарга Мал эмнэлэг, үржлийн газрын ерөнхий нягтлан бодогч	Авлагын дансанд давхар бичилт хийснийг залруулга хийх	965.5	
15	П.Дамдиндорж Н.Бат-Оюун	Мал эмнэлэг, үржлийн газрын дарга Мал эмнэлэг, үржлийн газрын ерөнхий нягтлан бодогч	Хугацаа хэтэрсэн зээлийн өрийг төлүүлэх	28.4	
16	Х.Гансүх	"ПРАЙМЛАЙС" ББСБ-ын гүйцэтгэх захирал	"ПРАЙМЛАЙС" ББСБ-аар дамжуулан олгож байсан хугацаа хэтэрсэн зээлийг төлүүлэх	30.5	
17	Р.Зоригт	Нийслэлийн ХХААГ-ын дарга	Төслөөр олгосон хөрөнгийг данс бүртгэлд тусгах	28.2	
18	Д.Болд Н.Оюунжаргал	Төв аймгийн Жаргалант сумын Засаг даргын орлогч ЗДТГ-ын хөдөө аж ахуйн мэргэжилтэн	Агропаркын хөрөнгийг ЗДТГ-ын дансанд тусгах	4.4	
19	Д.Болд Н.Оюунжаргал	Төв аймгийн Жаргалант сумын Засаг даргын орлогч ЗДТГ-ын хөдөө аж ахуйн мэргэжилтэн	2005 онд иргэдэд олгосон хугацаа хэтэрсэн зээлийг төлүүлэх	6.0	
Нийт дүн				204.8	6,311.1